

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ, СУМДЫН
2020 ОНЫ 08 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2020.09.04

Сүхбаатар сум

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар

Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас “Өрх бүр хүнсээ бэлтгэе”, аймгийн Засаг даргын санаачлагаар “Хамтын зүтгэлээр тарьж, өөрсдийн ургуулсан ногоогоо хэрэглэцгээе” уриалга гарган өрхийн тариаланг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан.

Тариалалтын төлөвлөгөөг бүрэн биелүүлж, тариалалтын эцсийн мэдээгээр 161.7 мян.га талбайд үр тариа тариалснаас улаан буудай 153.7 мян.га буюу 109 хувьтай, 958 га-д арвай, 4106 га-д овьёос, 1750 га гурвалжин будаа, тэжээлийн ургамал 8027 га буюу 70 хувьтай, тосны ургамал 25.3 мян.га буюу 141 хувьтай, төмс 2822 га буюу 112 хувьтай, хүнсний ногоо 2829 га буюу 108 хувьтай биелүүлсэн.

2020 оны ургац тогтоолтын урьдчилсан дүнгээр улаан буудай 2417 га талбай ургац алдаж, 148.0 мян.га талбай хураахаас нэгж га талбайгаас 13.2 цн буюу 194.8 мян.тн, тэжээлийн ургамал 10 га талбай ургац алдаж, 12774 га талбай хураахаас нэгж га талбайгаас 13 цн буюу 16811 тн, тосны ургамал 572 га талбай ургац алдаж, 24010 га талбай хураахаас нэгж га талбайгаас 6 цн буюу 16318 тн, төмс 29 га талбай ургаж алдаж, 2846 га талбай хураахаас нэгж га талбайгаас 97 цн буюу 27543 тн, хүнсний ногоо 37 га талбай ургац алдаж, 3017 га талбайгаас хураахаас нэгж га талбайгаас 102 цн буюу 30871 тн ургац хураан авах төлөвтэй байна.

Үр тарианы нийт тариалсан талбайгаас 4582 га талбайд болц гүйцээгүйгээс тэжээлд шилжиж, 2519 га талбай ганд нэрвэгдэж, 98 га талбай мөндөрт цохигдсон байна.

Ургац хураалтад 403 комбайн, 101 будаа цэвэрлэгч, 157 будаа ачигч, 32 төмсний комбайн, 5 даршны комбайн, 39 төмс ухагч, 32 хүнсний ногоо хураагч, 22 механикжсан үтрэмд ажиллахад техник засвар үйлчилгээний ажил хийгдэж, техникийн бэлэн байдал 92.8 хувьтай байна.

Одоо байгаа техникийн хүчин чадлаас хамааран намрын ургац хураалтыг үтрэмээс гурилын үйлдвэрт буудай нийлүүлэх талбай чөлөөлөх технологийн хугацаа 7-10 хоногийг оруулан тооцоход ургацыг 24-28 хоногт багтаан хураах техникийн тооцоо гарч байна.

Сэлэнгэ аймагт 08 дугаар сарын 10-наас 2 аж ахуйн нэгж ангилан хадалт хийж эхэлсэн тарианы болц харьцангуй жигд бус байна. Хаврын тариалалтын үеийн чийг, хугацаа, гол хатгалтын үе болон хэт халалтаас шалтгаалан таримлын болц харьцангуй жигд бус байна. Төмс, хүнсний ногооны хувьд хураалтын ажил 7 дугаар сарын 10-наас эхлэн эртийн хүнсний ногоог худалдаанд гаргасан,

өнөөдрийн байдлаар 5124 тн хүнсний ногоо, 1235 тн төмс хураан зах зээлд нийлүүлсэн мэдээтэй байна.

Одоогийн байдлаар үр тариа, төмс 155.2 га талбайгаас 1672,5 тн, хүнсний ногоо 496,2 га талбайгаас 4913,1 тн, үр тариа 920 талбайд ангилан хийж, 300 га талбайд шууд хураалт хийж 500 тн улаан буудай хураан авсан байна.

Борлуулалтыг нийслэлийн 7 цэгт Мандал, Сант, Зүүнбүрэн, Шаамар, Хушаат сумдын ногоочид төмс, хүнсний ногоог худалдан борлуулж байна.

Намрын ажилд нийт 1055 ажиллах хүчний захиалга өгсөн боловч яамнаас 693 оюутан ажиллуулах боломжтой гэсэн.

06 дугаар сарын эхэн 07-08 дугаар саруудад олон хоног үргэлжилсэн борооны улмаас голын түвшин нэмэгдэж, зарим сумдын гүүр, авто зам, даваа эвдэрч хувил үүссэн тээврийн хэрэгсэл явах боломжгүй ургац тээврийн авто зам засварын саналыг Зам тээвэр хөгжлийн яам, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлсэн.

- Баянгол сумаас Сайхан сум чиглэлийн Загдалын голын гүүрний засвар
- Улаанбаатар-Дархан-Уул аймаг чиглэлийн авто замын засвар
- Улаанбаатар Сэлэнгэ чиглэлийн олон улсын авто замаас Шаамар, Зүүнбүрэн, Түшиг чиглэлийн 120 км авто замын засвар
- Түшиг сумын Харгистайн давааны зам засвар
- Баруунбүрэн сумын доод Цагаан хөтөлийн давааны 5 км авто зам
- Хүдэр сумын Хазайн гүүр, зам засвар
- Ерөө сумын Хонгорын нурууны 6 км авто зам, Яргаатын 3 км авто зам, Цагаан тохойн 10 км авто замын засварын ажлуудыг хийлгэх саналыг хүргүүлсэн.

Хураалтын ажил эхэлсэнтэй холбогдуулан дээрх зам засварын ажлуудыг яаралтай засварлах хэрэгтэй байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны 02 дугаар “2020-2021 оны өвөлжилтийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” албан даалгавар гарган хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.

Сумдын халаалтыг 2020 оны 10 дугаар сарын 01-нээс өгөхөөр засварын ажил, өвлийн түлшний нөөцийг бүрдүүлэхээр ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуулийн 2020-2021 оны хичээлийн шинэ жил эхлэхтэй холбогдуулан бэлтгэл ажил бүрэн хангалаа. Аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын 35 сургуульд нийт 18824 сурагч 2 ээлжээр хичээллэж байгаагаас 74 бүлгийн 2420 хүүхэд 1-р ангид элсэн суралцаж байна.

Сургуулийн өмнөх боловсролын 35 цэцэрлэгийн 250 бүлэгт заавал хамрагдах ёстой 5 настай 2034, 4 настай 1741, 3 настай 1639 хүүхдээс байгаагаас 09-р сарын 01-ний өдрийн байдлаар 3802 хүүхэд хамрагдаад байна.

Баруунбүрэн сумын цэцэрлэг, Мандал сумын 1-р цэцэрлэг, Сайхан сумын 3-р цэцэрлэгийн засварын ажлын гүйцэтгэл хангагдаагүй учир хүүхэд хүлээн аваагүй байна.

Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуулийг Сэлэнгэ аймагт зохион байгуулах ажлын хэсгийг 2020 оны 07-р сарын 31-ний өдрийн Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 49 тоот

тогтоолоор 9 хүний бүрэлдэхүүнтэй байхаар баталж, аймгийн сонгуулийн хорооны даргаар аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Ө.Сувдаа томилогдон ажиллаж байна.

Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуулийн Сэлэнгэ аймгийн сонгуулийн хорооны бүрэлдэхүүнд:

- Аймагт 9,
- Сумдад 91 нийт 100 албан хаагч
- Хэсгийн хороонд 541 албан хаагч
- Мэдээлэл технологийн даамлаар аймагт 5, суманд 81, нийт 86 албан хаагч
- Иргэний бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтнаар суманд 65 нийт 792 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулахаар ажиллаж байна.

Дайчилгааны нэг, хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтыг 09 дүгээр сарын 04-ний өдрөөс, цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаахаар хүсэлт гаргасан Мандал, Зүүнбүрэн, Сант сумын иргэд болон Тусгай үүргийн сургалтад хамрагдах Баруунбүрэн, Сайхан, Сант, Хушаат сумдуудын иргэдтэй сургалт зохион байгуулах захирамжийн төсөл боловсруулан аймгийн Засаг даргаар батлуулан сургалтыг 09-р сарын 15-аас 10 хоногийн хугацаатай Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын сургалтын төвийг ашиглан явуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Онцгой байдлын ажил үйлчилгээний талаар:

Болзошгүй үерийн аюул, усны ослоос урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж үерийн далан, суваг шуудууг цэвэрлэх чиглэлийг Онцгой байдлын газрын дарга бөгөөд аймгийн Онцгой комиссын орлогч даргын албан бичгээр сумдуудад хүргүүлсэн.

Монгол Улсын Онцгой комиссын шийдвэрээр Коронавирус /COVID-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, иргэдийг татан авах ажлын хүрээнд 2020 оны 08 дугаар сарын 07-10-ны өдрүүдэд Сэлэнгэ аймгийн Хил хамгаалах болон Мэргэжлийн хяналтын байгууллага, Цагдаагийн газартай хамтран Оросын холбооны улсаас Монгол Улсын 95 иргэн, Оросын холбооны улсын 191, Америк улсын 1, Солонгос улсын 1, нийт 288 иргэн татан авч Монгол улсад нэвтрүүлсэн.

Үүнээс Улаанбаатарт-115, Дархан-Уул аймагт-99, Орхон аймагт-72, Сэлэнгэ аймагт-2 иргэнийг тусгаарлах байранд шилжүүлэх ажлыг зохион байгууллаа.

Тайлангийн хугацаанд тус газрын бие бүрэлдэхүүн объектын гал түймрийн 5, усны ослын дуудлага 3, аврах ажиллагааны 2 дуудлагаар гарч ажилласан.

Мандал сумын Ширхэнцэг багийн Хараа голын “Шумуулт” гэдэг газар Хурцболд овогтой Анар /2 настай, эрэгтэй/ Хараа голын усанд осолдсон тухай дуудлагыг 2020.08.14-ны өдрийн 17:12 цагт хүлээн авч Мандал сум дахь Онцгой байдлын хэлтсийн 10 алба хаагч 1 автомашин, 1 завь, Цагдаагийн хэлтсийн 23 алба хаагч, 3 автомашин, ар гэрийн 8 иргэн 1 автомашинтай нийт 41 хүн, 5 автомашинтайгаар, эрлийн ажиллагааг зохион байгуулж мөн өдрийн **18:26 цагт** нэрвэгдэгчийг олж, Цагдаагийн байгууллагад хүлээлгэн өгсөн.

Сүхбаатар сумын Буур хээр багийн “Өндөр эрэг” гэдэг газар Орхон голд Лувсангомбо овогтой Сүхбат /64 настай эрэгтэй/, Содном овогтой Аюур /70 настай эрэгтэй/ гэх 2 хүнусанд осолдсон гэх дуудлагыг 2020.08.18-ны өдрийн 16:22 цагт

хүлээн авч эрлийн ажиллагааг 13 хоног явуулахд буцалтгүй нэрвэгдэгч олдоогүй тул ар гэрийн хүсэлтээр эрлийн ажиллагааг 2020.08.31-ний өдрөөс тодорхойгүй хугацаагаар түр зогсоосон.

Сант сумын Ивэн 1 дүгээр багийн "Орхон голын гүүр" гэдэг газар Орхон голын усанд Ж.Анар-Эрдэнэ /22 настай эрэгтэй/, Н.Батзориг /23 настай эрэгтэй/, Г.Гантулга /24 настай, эрэгтэй/гэгч 3 иргэн осолдсон гэх дуудлагагыг 2020.08.24-ний өдрийн 15:30 цагт хүлээн авч Онцгой байдлын байгууллагын 41 алба хаагч, 6 автоамшин, 7 завь, Орхон аймгийн Барилгын цэргийн 110 дугаар ангийн 11 алба хаагч, Цагдаагийн байгууллагын 5 алба хаагч 1 техник хэрэгсэлтэйгээр эрлийн ажиллагааг зохион байгуулж, 2020.08.25-ны 15:46, 2020.08.27-ны 08:15, 2020.08.27-ны 11:20 цагуудад буцалтгүй нэрвэгдэгчдийг олж ар гэр, Цагдаагийн байгууллагад хүлээлгэн өгсөн.

Сүхбаатар сумын 3 дугаар баг 4 дүгээр хэсэг "Баянхан уул" гэдэг газар Тоёото приус 20 загварын суудлын автомашин уулын жалгаруу унах гэж байна гэсэн дуудлагыг 2020.08.08 ны 06:15 цагт хүлээн авч Онцгой байдлын газрын Эрэн хайх, аврах бүлгийн 5 алба хаагч, 1 автомашинтай 06:26 цагт очиж 94-09 СЭУ улсын дугаартай приус 20 загварын суудлын автомашинтай иргэд 2,5 метрийн гүнтэй жалганы ирмэгрүү зүүн талаараа хажуулдаж орсон байдалтай байсныг 1 цаг 30 минут ажиллаж татан гаргаж иргэн Д.Билэгтэд хүлээлгэж өгсөн.

Мандал сум Түнхэл 5-р баг Мэхээртийн даваа гэдэг газар Д.Ариунболд /35 настай эрэгтэй/ гэгч 99-93 УНИ Хондо Вагон загварын автомашинтай УБ-аас Мандал сум орох замд осолдож, эгэмний яс хугарсан дуудлагыг 2020.08.15-ны 02:00 цагт хүлээн авч Мандал сум дахь Онцгой байдлын хэлтсийн 5 алба хаагч 1 автомашин, Цагдаагийн хэлтсийн 4 алба хаагч, 1 автомашинтайгаар 03:10 цагт очин, иргэн Д.Ариунболдыг осолдсон газраас тээвэрлэн 06:15 цагт сумын эмнэлэгт хүлээлгэн өгсөн.

Мэргэжлийн хяналтын үйл ажиллагааны талаар:

2020 оны төлөвлөгөөт хяналт шалгалтаар 13 хуулийн этгээд, 20 иргэн төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар 9 хуулийн этгээд, 3 иргэн, урьдчилан сэргийлэх хяналтаар 163 хуулийн этгээд, 104 иргэн, тандалт судалгаар 39 хуулийн этгээд, 109 иргэн, хяналт шинжилгээгээр 2 хуулийн этгээд, 9 иргэн, нийт 422 зөрчил дутагдлыг илрүүлж, 243 зөрчлийг арилгуулан, 226 хуулийн этгээд, 245 иргэнд 350.500 төгрөгийн шийдвэрийн арга хэмжээ тооцож, 50.500 төгрөгийн торгуулийг барагдуулан, шалгалтын явцад албан шаардлага 227 заалттай, 8/65 зөвлөмжийг үйлдэн биелэлтийг тооцон ажиллалаа.

2020-2021 оны хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлыг хангуулах, Монгол Улсын Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан сумдын Засаг даргын Тамгын газартай цахимаар холбогдож, сургалт зохион байгууллаа. Сургалтанд ерөнхий боловсролын сургуулийн захирал, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын эрхлэгч, нярав, тогооч, сумдын худалдаа үйлчилгээ хариуцсан мэргэжилтнүүдийг бүрэн хамруулж, Коронавирус /COVID-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх талаар Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас "Үүрэг, чиглэл өгөх тухай" 03/322, 02/644 дугаартай албан бичгийн дагуу Сүхбаатар, Мандал, Шаамар сумын нутаг дэвсгэрт авто зам дагуу хүнсний

худалдаа, хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй 13 иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийлээ.

Шалгалтын явцад 36 зөрчил дутагдлыг илрүүлж газар дээр нь 30.5% буюу 11 зөрчил дутагдлыг арилгуулан, хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай улсын байцаагчдын хамтарсан 43 заалт бүхий 3 албан шаардлагыг хүргүүлэн хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.

Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлгийн Халдвартын тасагт ажиглалтад 4 иргэн, “Гүй Жоу Хавэй инженеринг групп” ХХК-ий тусгайлан бэлдсэн ажиглалтын байранд БНХАУ-ын 16 иргэн, Сэлэнгэ аймгийн харъяатай 21 иргэн үргэлжлүүлэн гэрийн ажиглалтад хянагдаж байна. Иргэдийн биеийн байдал хэвийн байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дэд даргын баталсан 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 01/69 дугаар удирдамж, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан 2020 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 01/96 дугаар удирдамжийн дагуу ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хоол үйлдвэрлэл, ундны усны эх үүсвэрээс. хоол үйлдвэрлэлийн хэсэгт хэрэглэж буй ундны уснаас ундны усны чанар, аюулгүй байдлын үзүүлэлт тодорхойлох зорилгоор нийт 19 дээж авч аймгийн Мэргэжлийн хяналтын газрын итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээнд хамрууллаа

УОК-ын 1835 тоот албан бичгийн дагуу Амарбаясгалант хийдэд Гонгорын бумбаны тахилгын үйл ажиллагааны явцад халдвар хамгааллын дэглэмд хяналт тавьж тахилга, хурал дууссаны дараа Амарбаясгалант хийдийн 3 дугана, гадна орчны зам талбайд нийт 1000 мкв талбайд халдваргүйтгэлийг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэн халдваргүйтгэлийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавьж ажиллалаа.

Стандартчилал, хэмжил зүйн үйл ажиллагааны талаар:

Стандартчилал, тохирлын үнэлгээ, баталгаажуулалтын чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

Ээлжит баталгаажуулалтын ажлаар Хүдэр, Ерөө, Шаамар, Алтанбулаг сумын 4 аж ахуйн нэгж, иргэний 4 үйлчилгээний газарт тохирлын үнэлгээ хийж, тохирлын гэрчилгээ олгож ажиллалаа.

Сүхбаатар сумын өрхийн үйлдвэрлэгч Э.Эрдэнэцэцэгийн үйлдвэрлэсэн нэрийн даршилсан өргөст хэмх, хүрэн манжин, алаг салат, даршилсан байцаа, даршилсан улаан лооль зэрэг 1 нэрийн 9 бүтээгдэхүүний хаяг шошгыг МУ-ын “MNS 6648:2016 Хүнсний бүтээгдэхүүний сав боодлын шошгололтонд тавих шаардлага” стандартад нийцүүлэн хийх талаар зөвлөмж өгөв.

Стандартын мэдээллийн салбар сангаас 3 аж ахуй нэгж байгууллага, иргэний захиалгын дагуу 3 нэрийн 5 стандартын борлуулалт хийж, 3 иргэнд арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Механикийн хэмжлийн төрлөөр: Худалдаа, үйлчилгээ, аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй 3 ширхэг жинг шалган, ээлжит бус баталгаажуулалтад хамруулан ажиллалаа.

Цахилгааны хэмжлийн төрлөөр: Хэрэглэгчдийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй 41 ширхэг цахилгааны тоолуур, 2 ширхэг даралтын аппаратыг шалган баталгаажуулсан.

Дулаан даралтын хэмжлийн төрлөөр: Иргэн, аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж буй 2 ширхэг цусны даралтын аппаратыг шалган баталгаажуулсан байна.

Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

Өнгөрсөн сард 711 баримтаар 9665459 сая төгрөгийн төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог хянан гүйцэтгэлээ.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр аймгийн web сайт, шилэн данс болон ил тод самбарт байршуулсан.

Аймгийн 07-р сарын орлогыг татварын хэлтэстэй тулган баталгаажуулсан.

ОНХСангийн хөрөнгө оруулалтын санхүүжилтыг сум бүрт хуваарилж тавьсан.

07 сарын ТЗШилжүүлгийн санхүүжилт тавьсан.

Нийт ААНБ-ын хагас жилийн тайланг хүлээн авч баталгаажуулсан.

Аймгийн 2021 оны төсвийн төсөл, 2022-2023 оны төсвийн төлөвлөгөөний саналыг харьяа байгууллага болон бүх сумдаас төсвийн санал хүлээн авсан.

ТЕЗ-н 2020 оны хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн гүйцэтгэлийн тайланг гаргаж Сангийн яаманд хүргүүлсэн.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
	1. Орон нутгийн төсвийн нийт орлого	62,634,676.4	55,485,653.5	88.6
	Орон нутгийн төсвийн орлого	13,674,430.9	13,087,230.8	95.7
1.1	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	10,545,464.0	9,630,277.5	91.3
	Сумдын төсвийн орлого	3,128,966.9	3,456,953.3	110.5
1.2	Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	4,091,456.7	4,091,456.7	100.0
1.3	Улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг	35,207,826.8	32,531,475.4	92.4
1.4	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг	4,235,312.7	2,135,761.9	50.4
1.5	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/	3,242,260.1	2,948,350.9	90.9
1.6	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/	691,377.8	691,377.8	100.0
1.7	Сум хөгжүүлэх сан /орлого/	1,492,011.4	494,988.5	33.2
	2. Орон нутгийн төсвийн нийт зарлага	62,634,676.4	47,549,920.3	75.9
	Орон нутгийн төсвийн нийт зарлага	62,634,676.4	47,549,920.3	75.9
2.1	Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага	11,911,764.5	8,617,103.2	72.3
	Сумдын орон нутгийн хөгжлийн сан	1,850,307.6	912,637.3	49.3
	Сумдын сум хөгжүүлэх сан			

	Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага	9,246,956.0	6,962,654.2	75.3
	Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт	1,405,088.8	427,984.1	30.5
	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	2,310,113.5	1,420,014.0	61.5
	Халамжийн сан	211,976.0	94,372.4	44.5
	Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага	5,017,426.3	4,738,500.5	94.4
	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө	302,351.4	281,783.3	93.2
	Сумдын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	38,950,653.9	30,407,590.6	78.1
	Аймгийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	674,994.4	649,935.0	96.3
3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг		49,247,195.1	42,838,246.8	87.0
3.1	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	9,804,055.6	8,171,009.6	83.3
3.2	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	1,631,042.4	1,111,774.0	68.2
	Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд	82,449.5	82,449.5	100.0
	Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд	-	-	
	Хөрөнгө оруулалтын зардалд	1,548,592.9	1,029,324.5	66.5
3.3	Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	2,604,270.3	1,023,987.9	39.3
	Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд	2,310,113.5	784,331.1	34.0
	Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд	272,500.0	218,000.0	80.0
	Усан хангамжийн татаас	21,656.8	21,656.8	100.0
3.4	Сумдад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	34,576,759.3	31,900,456.8	92.3
3.5	Аймагт олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	631,067.5	631,018.6	100.0
3.6	Тусгай зориулалтын шилжүүлэг /салбараар/	35,207,826.8	32,531,475.4	92.4
	- Ерөнхий боловсролын сургууль	19,444,757.5	18,612,191.0	95.7
	- Хүүхдийн цэцэрлэг	10,611,259.8	9,384,544.1	88.4
	- Эрүүл мэндийн байгууллага	4,430,307.1	4,430,307.1	100.0
	- Газрын кадастрын байгууллага	364,573.0	364,573.0	100.0
	- Хүүхдийн байгууллага	356,929.4	356,880.5	100.0
4. Тусгай сангуудын зарлага		1,492,011.4	494,988.5	33.2
4.1	Сумдын сум хөгжүүлэх сан	1,492,011.4	494,988.5	33.2

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл	2019 08- сар	2020 08- сар	2020- 08 2019-08 Х/төгрөгөөр/
-------------------------------------	-----------------	-----------------	-------------------------------------

1.ХҮНСНИЙ БАРАА				
1	ТАЛХ, ГУРИЛ, БУДАА			
	Гурил /савласан, кг/	1 100	1 200	109.1
	Талх /орон нутгийн, ш/	1 200	1 300	108.3
	Нарийн боов /кг/	2 500	2 600	104.0
	Будаа /кг/	2 400	2 600	108.3
	Элсэн чихэр /кг/	2 200	2 000	90.9
2	МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			
	Хонины мах /кг/	8 000	7 500	93.8
	Үхрийн мах /кг/	9 000	8 500	94.4
	Адууны мах /кг/	7500	7 000	93.3
	Ямааны мах /кг/	7 000	6 800	97.1
	Дотор мах, цувдай /цусгүй/	4000	5 000	125.0
	Хиам /чанасан, кг/	10 000	11 000	110.0
3	СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
	Сүү /задгай, л/	1 000	800	80.0
	Сүү / савласан, л/	2 700	3200	118.5
	Тараг /задгай, л/	1 300	1 000	76.9
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	15 000	16 000	106.7
	Айраг /л/	4 500	4 500	100.0
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4 500	4 500	100.0
	Өндөг /ш/	350	350	100.0
4	БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС			
	Ургамлын тос /л/	3 800	4 500	118.4
	Өөхөн тос /кг/	2 000	2 500	125.0
	Шар тос /кг/	13 000	15 000	115.4
	Масло /задгай, кг/	4 500	4 500	100.0
5	ХҮНСНИЙ НОГОО			
	Төмс /кг/	1 000	2500	250.0
	Лууван /кг/	1200	2 500	208.3
	Манжин /кг/	1200	3 000	250.0
	Байцаа /кг/	1500	1500	100.0
	Сонгино /кг/	1500	2 000	133.3
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	3 500	4 500	128.6
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	2 300	3 000	130.4
7	ШАТАХУУН			
	Бензин А - 80	1 750	1 370	78.3
	Бензин А - 92	1 850	1 420	76.8
	Дизелийн түлш	2 370	1990	84.0

Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

Аймгийн хэмжээнд 2020 оны эхний 8 сард 297 холбогдогчтой 955,8 сая төгрөгийн хохиролтой, 400 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 128-аар

буюу 24,2 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн илрүүлэлт 50,2 хувьтай байгаа нь өмнөх оноос 2,2 хувиар буурсан байна.

Аймгийн хэмжээнд 2020 оны эхний 8 сард 13218 зөрчил илрүүлсэн нь 5369 зөрчлөөр буюу 28,9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Улсын бүртгэлийн хэлтсээс 08 дугаар сард газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ 268, лавлагаа 1, газраас бусад үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээ 118, лавлагаа 4 олгож үйлчиллээ.

08 дугаар сард иргэний бүртгэлийн талаар:

- ✓ Төрсний бүртгэл – 258/эрэгтэй-131, эмэгтэй-127/
- ✓ Гэрлэлтийн бүртгэл – 37
- ✓ Гэрлэлт цуцалсны бүртгэл – 9
- ✓ Үрчлэлт - 4
- ✓ Эцэг тогтоолт – 7
- ✓ Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл – 12
- ✓ Нас баралт – 64
- ✓ Нийт олгосон иргэний үнэмлэх – 396
- ✓ Шинээр олгосон иргэний үнэмлэх – 143
- ✓ Дахин олгосон иргэний үнэмлэх – 62
- ✓ Иргэний үнэмлэхний хугацаа дуусч солиулсан – 191
- ✓ Гадаад паспорт олголт – 8
- ✓ Шилжин ирсэн – 543
- ✓ Хот доторх шилжилт – 437
- ✓ Лавлагаа - 675 тус тус бүртгэгдсэн байна.

Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1.Боловсрол, соёл урлаг, спортын талаар

Боловсрол, Шинжлэх ухааны сайдын 2020 оны А/17 дугаар тушаалаар баталсан “Ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх түр журам”-ын дагуу хичээлийн жилийн бэлтгэлийг бүрэн хангаж ажиллалаа.

Ерөнхий боловсролын сургуулиуд хичээл, сургалтын үйл ажиллагааг “Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих арга зүйн зөвлөмж”-ийн дагуу бэлтгэлээ хангаж, хэрэгжилтийг хангах чиглэл, зөвлөмж өгөх сургалтад нийт 285 багш, ажилтныг хамрууллаа.

Боловсрол Шинжлэх ухааны яамнаас 176 багшид зөөврийн компьютер олгоод байна. Дутагдалтай багш нарын судалгааг гаргасан бөгөөд 20 сургуульд, мэргэжлийн 37 багш шаардлагатай байна.

Мэргэжлийн байгууллагуудаас гаргасан зөвлөмжийн дагуу ариутгал халдваргүйтгэл бүх байгууллага дээр хийгдэж, багш ажилтнуудын 95 хувь эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдсан.

Борлуулалтын 4 цэгээр дамжуулан, 1 компани сурагчийн дүрэмт хувцсыг борлуулах ажлыг гүйцэтгэж байна.

Боловсролын салбарт нийт их засварын 6 ажил бүрэн, 3 ажил нь 80 хувьтай, 5 барилгын их засварын ажил дуусаагүй байна. 3 сургуулийн дотуур байр,

сургуулийн 1 өргөтгөлийн барилгын ажил дуусах шатандаа орсон бол 2 сургуулийн өргөтгөлийн ажил 2021 он дамжин хэрэгжихээр байна.

9 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар АНУ-ын цэргийн тусламжаар 1 цэцэрлэг ашиглалтад орж, энэ ондоо багтааж улсын төсвийн хөрөнгөөр 2 цэцэрлэг ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

Цар тахлын үед ард түмний эрүүл мэндийг хамгаалах, нийтийн биеийн тамирыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор Төв цэнгэлдэх хүрээлэнгийн гадна талбайд сагсны 2 шийдийг байрлуулж, иргэдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчин нөхцлийг бүрдүүлэн давхардсан тоогоор 1500 гаруй иргэд тогтмол хичээллэж байна.

Дасгал хөдөлгөөнөөр дархлааг нь дэмжих зорилгоор “Өглөө бүр эрч хүчтэй” уриан дор Партизаны талбай болон Гэрэлт цогцолбор дээр өдөр бүрийн 07 цаг 00 минутаас 07 цаг 30 минут хүртэл биеийн тамирын дасгал хийж тогтмол 350 гаруй иргэд хамрагдаж байна.

2. Эрүүл мэндийн талаар:

Аймгийн хэмжээнд коронавируст халдвар (КОВИД-19)-ын эрсдлээс урьдчилан сэргийлэх нөхцлийг бүрдүүлж, мэргэжлийн байгууллагуудын хяналтыг чангатган, тус халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар сургалт, сурталчилгаанд давхардсан тоогоор 145 иргэд хамрагдаж, цахим орчинд 32 мэдээлэл байршуулж, хандалт 463 иргэн, Эрүүл мэндийн яам, Улсын онцгой байдлын болон мэргэжлийн хяналтын байгууллагаас өгсөн урьдчилан сэргийлэх 423 санамж, зөвлөмжийг байгууллагуудад хүргүүлж, ил тод байршуулж хэвшсэн.

Улсын онцгой комиссын шийдвэрээр 2020 оны 8-р сард ОХУ-аар дамжин ирсэн нийт 27 иргэнийг тусгаарлаж, давхардсан тоогоор 765 жолоочоос сорьц авч, коронавирусийн батлагдсан тохиолдол 1 илэрсэн. Коронавирусийн батлагдсан 1 тохиолдлыг ХӨСҮТ-д хүлээлгэн өгсөн.

Түнхэл тосгонд “Халдварт ба халдварт бус өвчлөлийн эрт илрүүлгийн цогц үзлэг”-ийн ажиллагааг зохион байгуулж, 15 төрлийн үзлэгт 15-аас дээш насны 1500 хүн хамрагдахаас 627 хүн буюу хамрагдвал зохих хүн амын 41.8 хувийг хамрууллаа. УИХ-гишүүн Ч.Ундрам, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан нар үйл ажиллагаатай танилцан, орон нутгийн иргэдтэй уулзаж, аймгийн хэмжээнд эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, чадавхыг сайжруулахад чиглэсэн хийгдэх ажлуудаа танилцуулан, шаардлагатай тоног төхөөрөмжийг шийдвэрлэхээр боллоо.

Аймгийн хэмжээнд 17 сумын эрүүл мэндийн төвөөр дамжуулан “Хүүхдийг эхийн сүүгээр хооллох бодлогыг дэмжих дэлхийн 7 хоног”-ийг өрнүүлж 4 төрлийн сургалт, сурталчилгааг явуулж ажиллалаа.

3. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, нийгмийн даатгалын хүрээнд:

Халамжийн сангаас 36913 иргэнд 11480652,4 мянган төгрөгийг зарцууллаа.

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газраас зарласан тендэрт шалгарч “Сэргээн засах үйлчилгээ явуулах” эрх авсан “ЭБУС” ХХК, “Бум хараа” ХХК, “Энэрэлт үйлс” ХХК, “Хараа Алтан-Од” ХХК-уудтай хамтран ажиллах гэрээ

байгуулан Сэргээн засах үйлчилгээг Сүхбаатар, Мандал суманд зохион байгуулж нийт 271 ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэн хүүхдийг хамрууллаа.

2020 оны 8-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй 736 байсан бол 160 иргэн шинээр бүртгүүлж, ажил олгогчоос ирүүлсэн 95 ажлын байранд 83 хүнийг ажилд зуучилж, идэвхгүйн улмаас 218 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 595 болсон байна.

Өрхийн малжуулах арга хэмжээнд Баруунбүрэн, Сант, Зүүнбүрэн, Хушаат, Хүдэр, Ерөө сумд, Бугант, Хэрх тосгодын 30 өрхийг хамруулж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 141000.0 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд үүний үр дүнд 60 ажлын байрыг шинээр бий болголоо.

ХХҮЕГ-аас хөдөө орон нутагт сургалт зохион байгуулах эрх авсан “Эм Эс Девелопмент консалтинг” ХХК-ийн дэргэдэх Сургалтын төвтэй хамтран гэрээ байгуулан Баянгол, Мандал, Сайхан, Зүүнбүрэн, Сант сумдын зорилтот бүлгийн 130 иргэнийг хамруулж 5850.0 мянган төгрөг, Сүхбаатар сумын хөгжлийн бэрхшээлтэй 26 иргэдийг мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамруулж, 1820.0 мянган төгрөгийг тус тус зарцууллаа.

ХХҮЕГ-аас эрхтэй “Мэргэшсэн мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв”, Сэлэнгэ МСҮТ болон “Зүүнхараа” Политехникийн коллежтэй гэрээ байгуулан Сант, Сайхан сумд, Бугант тосгоны ажилгүй 42 иргэнийг хүлэмж, оёдол эсгүүр, хүнд машин механизмын операторчин мэргэжлээр сургаж байна.

Мандал сумын “Зүүнхараа” политехникийн коллежтэй хамтран 18 иргэнийг оёдол эсгүүрийн сургалтад хамрууллаа.

08 дугаар сарын байдлаар 21.1 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөтөйгээс 08-р сарын 31-ний байдлаар өссөн дүнгээр 25.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж 121.69 хувийн биелэлттэй байна

Тэтгэврийн даатгалын сангаас 17596 тэтгэвэр авагчдад 54,259,626 мянган төгрөгийг тэтгэвэрт, Тэтгэмжийн даатгалын сангаас 3973 хүнд 2,182,477 мянган төгрөгийг, хөдөлмөрийн чадвараа түр алдсан, жирэмсэн амаржсан, оршуулгын тэтгэмжид, Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас үйлдвэрлэлийн ослын тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, нөхөн төлбөр, сувиллын зардалд 247 хүнд 774,237 мянган төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 277 хүнд 735,497 мянган төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид тус тус олгосон байна.

4.Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар

1.Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвөөс 4 дуудлага мэдээллийг хүлээн авч, хамтарсан багт шилжүүлж, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэн ажиллалаа. Дуудлагыг агуулгаар нь ангилахад:

- Сэтгэл санааны хүчирхийлэл - 1
- Бие махбодын хүчирхийлэл - 3

Хүчирхийлэл үйлдэгдсэн орчноор нь ангилбал:

-Гэр бүлийн орчинд – 4

Эрсдэлийн түвшингөөр ангилбал:

-Дунд эрсдэлтэй – 2

-Бага эрсдэлтэй - 2

Тохиолдол дээр ажиллах:

-Нийт 4 тохиолдлыг хяналтандаа авч ажиллаж байна.

“Хөдөлмөр эрхлэгч хүүхдэд, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа” 2 сарын аяны хүрээнд: Хүүхдийн хөдөлмөрийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, ажлыг зохион байгууллаа. “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-аар хүүхэд ажиллахыг хориглосон ажлын байр, хүүхдийн хөдөлмөрийн мөлжлөгт өртөх эрсдэлтэй салбарын аж ахуй нэгж, байгууллагуудад хяналт, шалгалтын ажлыг 89 объектын хамруулан зохион байгуулж, тандалтаар албан бус секторт хөдөлмөр эрхэлж байгаа хүүхэд илрээгүй байна.

“Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг Дэлхийн өдөр”-ийг угтаж уриалгыг “Сэлэнгэ хүүхэд”, “Сэлэнгэ залуучуудын төв”, Сэлэнгэ ГБХЗХГ-ын сэтгэл зүйн цахим зөвлөгөө” цахим хуудсаар, Мандал сумын Хүүхдийн ордон, Орхонтуул сумын хүүхэд хөгжлийн төвөөр дамжуулан түгээх ажлыг зохион байгууллаа. Насанд хүрээгүй хүүхдийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт, уриалгыг сурталчлах зорилгоор 80 гаруй байгууллагууд, авто вокзал, Олон улсын худалдааны төв, банк зэрэг байгууллагуудын мэдээлийн самбарт байршууллаа.

“Олон Улсын Залуучуудын өдөр”-ийг тохиолдуулан залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх чиглэлээр:

-Сүхбаатар сумын төв цэцэрлэгт хүрээлэнд “Залуусын эв нэгдэл” холбоотой хамтран “Гудамжны номын сан байршууллаа.

-Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газартай хамтран залуучуудад цагийн болон байнгын ажлын байранд холбон зуучлах, үйлчилгээний талаар мэдээллэл солилцлоо.

-Шинээр гэр бүлийн батлах гардан авсан 2 залуу гэр бүлийг “Хайрын түүх” сэдэвт нэвтрүүлэгт урьж оролцуулан батламж гардууллаа.

-Аймгийн Нэгдсэн эмнэлгийн “Залуу эмч нар”-ын холбоотой хамтран мэс заслын тасгийг номын сантай болголоо.

-Сүхбаатар сумын “Үзэсгэлэнт сэтгэл”, “CALM” төрийн бус байгууллагуудтай хамтран залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх талбайтай боллоо.

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт ял эдэлж байгаа болон сахилгын арга хэмжээ авагдсан нийт 9 иргэнд “Гэр бүлийн хүчирхийлэл” сэдвээр сургалт зохион байгууллаа.

Тав.Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хүрээнд

1.Үйлдвэр, хөдөө аж, ахуй, мал эмнэлгийн үйлчилгээний талаар

Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 01 тоот албан даалгавар, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга, Монгол Улсын Ерөнхий малын эмчийн 02 тоот албан даалгавар, аймгийн Засаг даргын А/98 тоот захирамжийн хүрээнд 17 сумдад малын сэг зэм устгах, ариутгал халдварүйтгэл хийх ажил, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж байна.

Мал эмнэлгийн газрын даргын баталсан 02 тоот удирдамжийн дагуу мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн үйл ажиллагааны бэлэн байдал, стандартыг хангуулах үзлэг шалгалтыг хийж 8 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн

мэдээллийг мал эмнэлгийн нэгдсэн системд оруулж биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд мал сүргийн эрүүл мэндийн үзлэгээр аймгийн хэмжээнд давхардсан тоогоор адуу 11800 толгой, үхэр 128400 толгой, хонь 752480 толгой, ямаа 395210 толгой, амьтан 12420 толгой буюу нийт 1300.2 мян.толгой мал, амьтан хамрагдсан байна.

Мал эмнэлгийн нэгдсэн цахим системийг ажиллуулах талаар МЭЕГ-аас ирүүлсэн үүрэг чиглэлийн дагуу мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн малын эмч нарт мал эмнэлгийн үйлчилгээний талаарх мэдээ мэдээлэл, бүртгэл мэдээллийг оруулах талаар заавар, зөвлөгөө өгч мал эмнэлгийн нэгдсэн системээр мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.

Газар тариалангийн тогтвортой хөгжлийг хангах арга хэмжээний хүрээнд Засгийн газрын тогтоолын хэрэгжилт, цар тахлын онцгой нөхцөл байдал үүссэн энэ цаг үед, үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний хангамжийг нэмэгдүүлэх, нөөц бүрдүүлэх, дотоодод үйлдвэрлэх, 2020 оны тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газраас олгох 150,0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлэнд хамруулахаар үр тарианы 277 аж ахуй нэгж, 160 иргэн, төмс, хүнсний ногооны 95 аж ахуйн нэгж, 2251 иргэний судалгааг авч Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яаманд уламжлан арилжааны банкуудаар зээл олгогдож эхлээд байна.

Сэлэнгэ аймгийн өрх бүр өөрсдийн хэрэгцээний төмс, хүнсний ногоогоо тарьж ургуулан өрхийн хэрэгцээгээ хангахыг уриалан төмс, хүнсний ногооны тариалах талбайн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор Шинэ хөдөө төслийн хүрээнд Төмс, хүнсний ногооны үр олгох, Өсвөрийн хээлтүүлэгч олгох, Ногоон тэжээлийн үр олгох, Хүлэмж олгох гэсэн 4 багц тендерийг зарлаж, 4 аж ахуйн нэгжтэй шууд гэрээ байгуулан ажиллаж байна.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд 1,6 сая мал өвөлжих бөгөөд аймаг сумын өвс тэжээлийн аюулгүй нөөц өвс 2000 тн, тэжээл 600 тн бэлтгэх шаардлагтай байна.

2020-2021 оны мал өвөлжилт, хаваржилтад шаардагдах малчдын түвшинд бэлтгэх тэжээлийн хэрэгцээ:

- Байгалийн хадлан : 191596 тн
- Үйлдвэрийн тэжээл: 40874 тн
- Давс, хужир, шүү: 10218 тн тус тус бэлтгэнэ.

Намрын хадлан тэжээл бэлтгэлийн ажил эхэлж байгаатай холбогдуулан сумдад хадлангийн газар хуваарилах гэрээ байгуулах, бэлчээр хадлангийн ургац тогтоох бэлтгэл ажил, орон нутгийн малчид техникийн засвар үйлчилгээг хийж эхлээд байна. Мөн ургац хураалт, хадлан тэжээлийн бэлтгэл ажлыг ханган хүн хүч, техникийн бэлэн байдал цаг агаарын үүсэж болзошгүй нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулан шуурхай удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллах тухай чиглэлийг сумдад хүргүүллээ.

2. Байгаль орчны талаар

Бүх нийтээр мод тарих өдрөөр “Өрх бүр хашаандаа 2 мод тарья” уриалга гаргаж байгууллагын цахим хуудас болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчилж, Сүхбаатар самбар дээр “Өрх бүр хашаандаа 2 мод тарья” уриалга бүхий самбар байршуулсан. Мод тарих хялбаршуулсан гарын авлага, уриалга бүхий тараах материалыг бүх сумдад хүргүүлэн ажилласан. Аймгийн төв Сүхбаатар суманд шинээр байгуулсан “Ногоон төгөл”-д хайлаас 200 ширхэг, шинэс 20 ширхэг, гацуур 10 ширхэг, голт бор 76 ширхэгийг тус тус тарьсан.

Сумдын Засаг дарга нарт 2021 онд бэлтгэх модны саналыг холбогдох журмын дагуу ирүүлэх тухай албан бичгийг хүргүүлж саналыг нэгтгэн ажиллалаа.

Аймгийн Цагдаагийн газрын Экологийн цагдаа нартай хамтран хууль бусаар ан амьтан агнах, барих үйлдлийг таслан зогсоох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор Сүхбаатар сумын “Олон улсын худалдааны төв”-д утсан загас худалддаг иргэдтэй уулзаж борлуулж буй загасны холбогдох бичиг баримтуудыг шалгаж, 30 гаруй иргэнд хууль тогтоомжуудыг сурталчилан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. Экологийн цагдаа нартай хамтран хяналт шалгалт явуулахад Сүхбаатар сумын 1-р баг Хонгор морьтод хууль бусаар 100 гаруй загас барьсан иргэнийг илрүүлэн эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байна.

Хоггүй цэвэрхэн Сэлэнгэ аяны хүрээнд 2020 оны “Дахивар хаягдал нягтруулан шахах төхөөрөмж суурилуулах” ажлын гэрээг Сан-Оргиу ХХК-тай байгуулан ажилласан. “Дахивар хаягдал нягтруулан шахах төхөөрөмж”, 10 боодол зориулалтын төмөр утас, 100х300 хэмжээтэй 1 ширхэг ангилдаг хогийн сав, Хог хаягдлын гарын авлага тараах материал 500 ширхэг, цахим орчинд 2 төрлийн шторк хийх, орон нутгийн ТВ-гээр нэвтрүүлэг хийлгэх ажлуудыг хийж гүйцэтгүүлэн хүлээн авсан. “Эккодус пикчерс” ХХК-тай гэрээ байгуулан 2 шторк, 1 захиалгат нэвтрүүлэг хийж “facebook” хуудсаар мэдээллийг тухай бүр түгээж ажиллалаа.

3.Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын талаар

Газрын даргын 2020 оны А/30 тоот тушаалаар “Салбарын хууль тогтоомжийг таниулан сурталчлах” зорилгоор сумдын даамлын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээг 16 суманд хийж 2017-2020 онд иргэн аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлж, өмчлүүлж, ашиглуулахдаа ГЗБТЖилийн төлөвлөгөөнд тусгасан эсэх, дуудлага худалдаагаар газар эзэмшүүлэхдээ Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолыг мөрдөж ажилласан эсэх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний зарцуулалт болон хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж гарсан зөрчлийг арилгаж хариу ирүүлэх талаар албаны 2020 оны 01/55 тоотоор хүргүүлж ажиллалаа.

Газар өмчилж, эзэмшиж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагын мэргэжлийн байгууллагаар хэмжилт, боловсруулалт хийлгэсэн 18 нэгж талбарын кадастрын зургийг хүлээн авч аймгийн газрын кадастрын мэдээллийн нэгдсэн сан Лэнд менежер програмд бүртгэж баталгаажуулсан. Мөн Сүхбаатар сумын 36 иргэнд шинэчилсэн хаягаар кадастрын зургийг үнэт цаасан дээр хэвлэн иргэдэд үйлчилгээ үзүүлсэн байна.

Газар өмчлөх эрх шилжүүлэх 6 иргэний өргөдөл хүсэлтийг хүлээн авч газрын кадастрын мэдээллийн санд өмчлөх эрхийг шилжүүлж бүртгэлжүүлэн кадастрын зургаар үйлчилгээ үзүүлсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт нийт 10 иргэн, 1 аж ахуй нэгжийн лавлагаа болон мэдээлэл, бүртгэлийг гаргаж хүргүүлсэн

Банк болон банк санхүүгийн байгууллагад газар эзэмших эрхийн гэрчилгээгээ барьцаалан зээл авч байгаа 4 иргэний газар эзэмших эрхийн барьцааны бүртгэлийг газрын цахим биржид бүртгэлжүүлэн 2 иргэн аж ахуйн нэгжийн барьцааг чөлөөлж газрын мэдээллийн санд холбон ажилласан.

Барилга, Хот байгуулалтын Сайдын 2020 оны 38 дугаар тушаалаар батлагдсан “Хот байгуулалтын мэдээллийн сангийн журам”-ийн хэрэгжилтийг хангуулах, ГЗБГЗЗГ-ийн Даргын 2019 оны 05 дугаар сарын 15- ний өдрийн А/96 тоот тушаалаар “Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сан”-ийн өгөгдөл бүрдүүлэх инженерийн дэд бүтцийн цахилгаан хангамж, дулаан хангамж, ус хангамж, ариутгах татуурга, хот тохижилт, ногоон байгууламжийн авто зогсоол, усан оргилуур, явган болон дугуйн зам, хөшөө дурсгал, гудамж талбайн гэрэлтүүлгийн мэдээлэл бүртгэх маягт батлагдсан ба эдгээр маягтаар хөгжүүлсэн байрлалд суурилсан цахим вэб програм хангамжийг хэрэглээнд нэвтрүүлэх ажлын программд нийт 354 барилга байгууламж мэдээллийн санд бүртгэсэн үеийн фасад зургийг нөхөж оруулж ажиллаж байна.

4.Ус, цаг уур, байгаль орчны хяналт судалгааны мэдээ мэдээлэл:

Хур тунадас: 2020 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар: 1, 6, 7, 9, 12, 13-нд нийт нутгаар 0,0-38,0 мм, 2-нд зүүн хойд хэсгээр, 3, 8-нд хойд хэсгээр, 5-нд өмнөд хэсгээр, 14, 15-нд баруун хойд хэсгээр 0,0-20,0 мм бороо орлоо. Бусад хугацаанд бороо ороогүй. Салхи: 8-р сарын 1, 7, 12, 13, 14, 15-нд салхи түр зуур ширүүсч 10-15 м/сек байв.Бусад хугацаанд салхи баруун болон баруун хойноос 5-10 м/сек байв.

Агаарын температур: Ихэнх хугацаанд агаарын температур шөнөдөө 10-15 градус, өдөртөө 22-27 градус дулаан байлаа. 18,19-нд шөнөдөө хүйтэрч 4-10 градус дулаан байв.

Сэлэнгэ аймгийн голуудын усны түвшний тойм мэдээ 21-ний байдлаар:Сэлэнгэ мөрний усны түвшин Зүүнбүрэн сум орчмоор 296 см, ОЖД-аас 22 см-ээр их, Сүхбаатар сум орчим 433 см, ОЖД-аас 76 см-ээр их, Орхон голын усны түвшин Орхон сум орчмоор 171 см, ОЖД-аас 8 см-ээр бага, Сүхбаатар сум орчмоор 320 см, ОЖД-аас 88 см-ээр их, Ерөө голын усны түвшин Бугант тосгон орчим 366 см, ОЖД-аас 96 см-ээр их, Ерөө сум орчмоор 399 см, ОЖД-аас 92 см-ээр их, Дулаанхан сумаар 426 см, ОЖД-аас 146 см-ээр их, Хараа голын усны түвшин Баянгол сум орчмоор 189 см, ОЖД-аас 11 см-ээр бага, Хүдэр голын усны түвшин Хүдэр сумаар 299 см, ОЖД-аас 77 см-ээр их, Зэлтэр голын усны түвшин Түшиг сум орчим 260 см, ОЖД-аас 9 см-ээр бага байна.

ХАА үйлдвэрлэлд: Бэлчээрийн ургамлын үе шат, өндөр, ургалтын байдал: 8-дугаар сарын 20-ны байдлаар ургамлын ургалтын байдал 80 гаруй хувьд нь сайн, 20 орчим хувьд дунд, ургамлын дундаж өндөр 12-49 см байна.

Улаанбуудайн ургалтын байдал нийт сумдын нутгаар сайн, Баянгол түрүүлэлт, Цагааннуур аарцан бололт, Орхонтуул бүрэн бололт, Орхон, Ерөө аарцан бололтын үе шатанд орсон, ургамлын дундаж өндөр 50-74см. МАА-н үйлдвэрлэлд хужир шүү бэлтгэх, мал оторлох, газар тариалангийн үйлдвэрлэлд, төмс хүнсний ногоо хураах, уринш боловсруулах, ангилан хадах ажилууд явагдаж байна.

Хөрсний чийгшил: Буудай, төмсний талбайн 0-20 см-ийн гүнд Баянгол, Цагааннуур хангалтгүй, Орхон, Ерөө, Орхонтуул, Мандал сумдын нутгаар хангалттай, 0-50 см-ийн гүнд Баянгол хангалтгүй, Орхон, Ерөө, Цагааннуур, Мандал хангалттай, 0-100 см-ийн гүнд Баянгол, Орхонтуул, Цагааннуур хангалтгүй, Баруунхараа дунд, Орхон, Ерөө, Мандал сумдын нутгаар хангалттай.

Бэлчээрийн талбайн 0-20,0-50 см-ийн гүндүүдэд Баянгол дунд, Ерөө хангалттай, Орхон хангалтгүй, 0-100 см-ийн гүнд Баянгол, Орхон хангалтгүй, Ерөө, Баянгол дунд гэсэн үнэлгээтэй байна.

Бэлчээрийн ургамлын хөнөөлт царцааны ажиглалт: Сүхбаатар, Баянгол, Ерөө, Мандал, Зүүнбүрэн, Түшиг, Хүдэр сумдын нутгаар бараан далавчит, тонолжилт, барбины таршаа, сибирийн царцаа ажиглагдсан бөгөөд 1м²-т хүрээнд дундажаар 2-7 ширхэг царцаа тоологдсон бусад сумдын нутгаар царцаа ажиглагдаагүй.

2020 оны 8-р сарын хоёрдугаар арав хоногийн агаарын чанарын мэдээ: Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын агаарын чанарын харуулын 8-р сарын хоёрдугаар арав хоногийн ажиглалтын дүнгээс үзэхэд агаар дахь хүхэрлэг хийн дундаж агууламж 0.002 мг/м³, хамгийн их нь 0.005 мг/м³, азотын давхар ислийн дундаж агууламж 0.032 мг/м³, хамгийн их нь 0.045 мг/м³, нийт тоосны дундаж агууламж 0.062 мг/м³, хамгийн их нь 0.076 мг/м³, рт.10 тоосонцор болон хөрсөн дээрхи цацрагийн түвшин фон түвшнээс даваагүй байна.

Зургаа.Сум орон нутгийн ажил үйлчилгээний талаар:

Алтанбулаг сум:

Сумын Засаг даргын Тамгын газар нь 2020 оны 08 дугаар сарын 11, 12-ны өдрүүдэд 2016-2020 онд тус суманд хийгдсэн бүтээн байгуулалтын ажлын тайлант сэтгүүл болон төрийн үйлчилгээний мэдээллийг хүргэх зорилгоор 2 дугаар багийн зах хэсэг, 3 дугаар багийн Хярааны хэсгийн өрхүүдэд мэдээлэл хүргэх ажлыг зохион байгууллаа. Тус ажлын хүрээнд 38 иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа, санал хүсэлтийг авч, холбогдох арга хэмжээг авч ажилласан.

“Өвөлжилтийн бэлтгэл ажил хангах тухай” сумын Засаг даргын 2020 оны А/107 тоот захирамжийг байгууллага аж ахуйн нэгжүүдэд хүргүүлж, бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг үүрэг болгон заавар зөвлөгөө өгч ажиллалаа. Уг ажлын хүрээнд хадлангийн газрын гэрээг 161 өрх, 4 аж ахуй нэгжтэй байгуулан иргэд аж ахуй нэгжүүд хадландаа гарч эхлээд байна.

Хөдөө аж ахуйн тасгаас зориулалтын бус хуванцар савны хэрэглээ, өвөлжилтийн бэлтгэл хангах талаар, мэргэжилтнүүд өөрсдийн цаг үетэй холбоотой ажлын талаар иргэдэд мэдээлэл хүргэж, нийт 104 иргэнд гарын авлага зөвлөмжийг хүргэлээ.

Сумын малчин, мал бүхий өрхүүдээс ноосны падааныг авч нэгтгэлийг аймгийн ХХААГ-т хүргүүлээ.

Аймгийн Засаг даргын 02 албан даалгаврын дагуу төлөвлөгөө гарган 2020 оны 08 дугаар сарын 18,19-ний өдөр ургацын урьдчилсан тогтоолтын ажлын хэсэг аж ахуй нэгж, иргэдийн тариалангийн талбайгаар явж урьдчилсан тогтоолтын дүн мэдээг гарган аймгийн ХХААГ-т хүргүүлэн ажиллалаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй сумын эрүүл мэндийн төвийн барилгын гадна талын 1600 куб талбайг тохижуулах ажлыг 2020 оны 07-р сарын 28-ны өдрөөс 08-р сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд хийж гүйцэтгэсэн ба гадна хашаа, орох хаалгыг будах ажилд 420.000 төгрөгийн санхүүжилтийг зарцуулсан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар ахмадын байрны их засварын ажил эхлээд, гадна засварын ажил 60%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байна.

Азийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа замын ажлын явцад хяналт тавьж ажиллаж байна.

Баруунбүрэн сум:

ХАА-н тасаг нь ургац тогтоох ажлын хэсгийг сумын Засаг даргын захирамжаар байгуулан 08-р сарын 17-19-ны өдрүүдэд тариалалт хийсэн аж ахуй нэгж, иргэдийн талбай бүрээр тойрч ургацын урьдчилсан балансын дүнг гаргалаа. Урьдчилсан тогтоолтын дүнгээр 10086 га талбайд үр тариа тариалсны 500 га талбай нь тэжээлд, 490 га талбай ганд нэрвэгдэж, 9096 га талбайгаас 11269 тонн буюу нэгж га талбайгаас 12,4 цн ургац, төмс, хүнсний ногооны хувьд ургац алдсан талбай байхгүй 180,63 га талбайгаас 2067,2 тн төмс, хүнсний ногоо буюу нэгж га талбайгаас 110 цн ургац хураан авахаар урьдчилсан дүн гарсан байна.

Бог малын ялган суурилсан 4 суурьт Засаг даргын захирамжаар тогтоосон газарт намаржуулах ажлыг зохион байгуулж зохих газарт нь буулгасан.

2020 онд ноосны урамшуулалд хамрагдах 317 малчны 70 тонн ноосны материалыг бүрдүүлж ХХААГ-т хүргүүлсэн.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг сумын хэмжээнд 88046 толгой мал, амьтадыг хамруулахаас 84039 толгой буюу 94,4%, боловсруулалт 100%, туулга бод, бог, гахай-100%, угаалга бод-49,7%, бог-15%-тай байна.

Малын бурцелёзын вакциныг “Бүрэнсүрэг МЭҮН”, “Батцэнгүүн МЭҮН”-т аймгийн Засаг даргын захирамж, зөвлөмжийг танилцууж, хөдөлмөр аюулгүй байдлын талаар мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөө өгч ажлыг хувиарлан өгсөн.

Вакцинжуулалтын баримт материалыг цахим бүртгэлийн системтэй тулгалт хийж, Сэлэнгэ аймгийн Мал эмнэлгийн газарт хүргүүлэхэд бэлэн болгосон. Мал эмнэлгийн үйл ажиллагаа явуулж байгаа 2 нэгжид ирсэн дуудлага, үзлэг тандалтын талаарх мэдээ мэдээллийг өдөр бүр мал эмнэлгийн шуурхай штабт, сумын шуурхай штабт өдөр бүр хүргэн ажиллаж байна.

Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлыг сумын бэлчээр бүхий 2 багийн нутаг 7 цэгт хийж сумын бэлчээрийн даац, чадавхийг тодорхойлох ажлыг хийж гүйцэтгэсэн.

“Дасгалаар дархлаагаа дэмжье” аяны хүрээнд төсөвт 6 байгууллага, ард иргэд ААН-үүдэд дасгал хөдөлгөөний ач холбогдлын талаар гарын авлагыг

тарааж, зөвлөгөө өгч, Баруунбүрэн спорт заал гэсэн фэйсбүүк хаягаас 40 удаа дасгал зөвлөмж хичээлийг нийтэлж ажиллалаа.

Сэлэнгэ аймгийн Орхон бүсийн Соёлын төвийн бүсийн өдөрлөг Сант суманд болж, Сант Хушаат багийн иргэдэд урлагийн тоглолт, тэмцээн зохион байгуулахад оролцсон.

Шинэ коронавирусын үед хэрэглэгдэх яаралтай тусламжийн эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц, нэг удаагийн хамгаалах хувцах хэрэгсэл, амны хаалтыг эмнэлгийн ажилчид хүн бүрт 3-5 удаагийн хүрэлцэхүйц хэмжээний нөөц, түргэн тусламжийн машин, шатахууны нөөц, орны нөөцийг бэлдэн ажиллаж байна.

Шинэ коронавирусээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг өдөр бүр цахим орчинд тавьж, 14 нэр төрлийн 230 ширхэг гарын авлага хэвлэж, ард иргэдэд өдөр бүр тарааж, мэдээлэл сургалт, сурталчилгааг тогтмол хийж байна.

Цахим орчинд “Ковид-19” өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж, дархлаа дэмжих дасгалуудыг нийтлэн ажиллаж байна.

Баянгол сум:

2020-2021 оны хичээлийн шинэ жил эхлэхтэй холбогдуулан “Бороо гоулд” ХХК-тай хамтран зорилтод бүлгийн, бүтэн өнчин, хагас өнчин, амьжиргааны түвшин доогуур орлоготой өрхийн цэцэрлэгийн ахлах, бэлтгэл бүлгийн 15, сургуулийн 1-6-р ангийн 60, нийт 75 хүүхдэд цүнх, хичээлийн хэрэгслийг 9-р сарын 1-ний өдөр хичээлийн нээлтийн үеэр гардуулан өгөхөөр болоод байна.

Мөн хичээлийн шинэ жил эхлэхтэй холбогдуулан хүүхдийн эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдалд хяналт тавих зорилгоор 8-р сарын 9, 12, 13-ны өдрүүдэд суманд үйл ажиллагаа явуулж буй хүнсний дэлгүүр, нийтийн хоолны газруудад үзлэг шинжилгээнд хамрагдсан байдал, ариун цэвэр, хугацаа дууссан бараанд 2 удаагийн үзлэг, хяналт шалгалтаар 919.700 төгрөгийн бараа хураан авч устгалд оруулсан.

Сургуулийн өмнөх боловсролын 2-5 насны 487 хүүхдийн судалгааг гаргаж, заавал хамрагдах 5 настай 132 хүүхдээс цэцэрлэгт хамрагдаж байгаагүй хүүхдүүдийн эцэг эхчүүдтэй холбогдон заавал хамруулахыг сануулан ажиллалаа.

“Бороо Гоулд” ХХК-иас дүйцүүлэн нөхөн сэргээлтийн сургалт мэдээллийн арга хэмжээг ариутгал халдваргүйтгэл, халдвар хамгааллын дэглэмийг барьж зохион байгуулсан. Сургалтанд 100 хүн оролцсон.

Хур системээс нийт 68 иргэнд үйлчилгээ үзүүлж ажиллалаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй 400 хүний суудалтай соёлын төвийн барилгын ажлын гүйцэтгэл 95 хувьтай байна.

“Соёлын ажилчдын баяр”-ыг угтан “Соёлын ажил бидний бахархал”, “Баянгол сумын танилцуулга”, “Түүх соёлын дурсгалт газрууд” сэдэвт мэдээлэл, “Орон нутгаа хэн сайн мэдэх вэ?” А.Х.А тэмцээнийг зохион байгуулж ажилласан.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуулийн 2020-2021 оны хичээлийн шинэ жилийн үйл ажиллагааг эхлүүлэх шийдвэр гарсантай холбогдуулан коронавируст COVID-19 халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, бэлтгэл ажлыг хангуулах зорилгоор Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/145 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтанд тусгагдсаны дагуу

сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш болон ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн багш, дотуур байрны багш нар, хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд оролцогч ажиллагсдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулах ажлын хүрээнд нийт 30 багш, ажиллагсдыг хамруулаад байна.

Мөн ажлын хүрээнд Монгол Улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтад тусгагдсаны дагуу Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комиссоос ариутгал, халдваргүйтэл, шавьж, мэрэгчгүйтгэлийн чиглэлээр тусгай зөвшөөрөл олгогдсон аж ахуйн нэгжээр хичээлийн болон дотуур байранд ариутгал, халдваргүйтгэлийг хийлгүүлэн гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Сэлэнгэ аймгийн тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа "Мөнх Ариун Сэлэнгэ" байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж төрийн болон төрийн бус байгууллагын 19 аж ахуйн нэгжийн нийт 4849 м² талбайд ариутгал, халдваргүйжилтийг хийж ажилласан. Дотоод нөөцөө ашиглан жавелионы уусмалаар халдваргүйтгэл, ариутгалыг тогтмол хийж байна.

Баянгол сумын айл өрхүүдийн нүхэн жорлонд ариутгал, халдваргүйтгэл хийх аяныг өрнүүлсэн. Аяны хүрээнд 249 өрхийн нүхэн жорлонг халдваргүйжүүлсэн.

Баянгол сумын замаар зорчин өнгөрч буй тээврийн 194 машинд ариутгал, халдваргүйтгэл хийж ажиллалаа.

Сумын 3428 иргэнд "Коронавирус өвчнөөс сэргийллэе" сэдэвт сургалт зохион байгуулсан.

Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас хэрэгжүүлж буй Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэх ур чадвар олгох хөтөлбөрийн хүрээнд Сэлэнгэ аймгийн ХХҮГ-тай хамтран "Хөдөлмөрт бэлтгэх" сургалтанд 35 иргэнийг хамруулж 30 иргэнд сертификат олголоо.

2020 оны 08 дугаар сард ажил идэвхтэй хайгч ажилгүй 16 иргэнийг байнгын шинэ ажлын байранд холбон зуучилж ажилласан байна.

Ерөө сум:

Сумын Засаг даргын 2020 оны "Өвөлжилтийн бэлтгэл ажил хангах тухай" захирамжын дагуу 8-р сард 1, 2-р багийн 215 иргэний хадлан бэлтгэх хүсэлтийг хүлээн аваад байна. Мөн 2020 оны ноосны урамшуулалд хамруулахаар 1,2,3-р багийн 110 малчин, мал бүхий өрхийн 126 ширхэг падааны жагсаалт үйлдэн Сэлэнгэ аймгийн ХХААГ-т хүргүүлээд байна.

Засаг даргын А/113 тоот захирамжын дагуу ажлын хэсэг 8 дугаар сарын 13-15-ны өдрүүдэд улаанбуудай тариалсан 13468 га талбайд урьдчилсан ургац тогтоолт хийж ажиллаа. Сумын дундаж ургац 15,1 цн үнэлэгдлээ.

Сумын Засаг даргын 2020 оны А/106 тоот захирамжаар "Сумын хэмжээнд бэлчээрийн төлөв байдал, чанарын өөрчлөлтийн явцыг хянах, цаг тухайд нь илрүүлэх, урьдчилан сэргийлэх, хэрэглэгчдийг мэдээллээр хангаж бэлчээрийг зохистой ашиглах нөхцлийг бүрдүүлэх, мэдээллийн сан үүсгэх чиг үүрэг бүхий ажлын хэсэг"-ийг газрын даамал, багийн Засаг дарга нар, ХАА-н мэргэжилтэний

бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, мониторингийн цэгийг газар дээр нь тэмдэгжүүлэхэд шаардагдах материалыг бэлтгэн 2020 оны 08 сарын 06,07-ны өдрүүдэд 1,2-р багийн 6 байршилд хийж гүйцэтгэлээ.

Сумын Засаг даргын 2020 оны А/98 тоот захирамжийн хүрээнд бичил уурхайгаар ашигт малтмал олборлохоор хүсэлт гаргасан нийт 86 нөхөрлөлийн өргөдөл материалыг хүлээн авч, журмын дагуу 10 нөхөрлөлийг сонгон шалгарууллаа. МөнӨлөнт, Харгана, Цамхаг, Могой, Ялбаг, Бэрлэгийн цагаан тохой, Их алт гэх газарт хууль бусаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулж буй, ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд газар дээр нь хяналт тавьж ажиллалаа.

Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль, дүрэм, журмыг олон нийтэд сурталчилах, холбогдох зөвлөмжөөр хангах, сургалт явуулах зорилгоор “Улсын бүртгэл” мэдээллийн самбаруудад Улсын бүртгэлийн багц хуулиудын шинэчилсэн найруулгаар баяжилт хийх, гарын авлага тараах материалууд бэлтгэх, Аймаг нийслэл, сум дүүргийн ИТХ-ын сонгуулийн хуулийн 20-р зүйл, сонгогч мэдээллээ burtgel.mn хаягаас өөрийн РД-аар орж нягтлан шалгах, шилжилт хөдөлгөөний бүртгэл түр зогсох талаар Ерөө сумын ЗДТГ-ын хамт олон цахим хаягаар сурталчилах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

“Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуйг эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах 91-92 мон” төслөөс Увс аймгийн Улаангом сумын тариаланчдын ногооны аж ахуйн үйлдвэрлэлийн ололт, амжилт, арга туршлагыг судлах талбайн өдөрлөг, сургалт 2020 оны 8 дугаар сарын 19-21 хооронд Увс аймгийн Улаангом суманд зохион байгуулагдлаа. Туршлага судлах арга хэмжээнд сумын 12 ногоочин оролцож мэдлэг чадвараа дээшлүүлж, сум хоорондын ногоочдын хамтын ажиллагаагаа хөгжүүлэх сургалтанд амжилттай хамрагдлаа. Тус арга хэмжээнд ХХААХҮЯ-ны ГТХБЗГ-ын шинжээч Н.Оюунсүвд, мэргэжилтэн Э.Уламбаатар, УГТХ-ын Дархан-Уул аймаг болон Увс аймгийн Улаангом дахь салбар төлөөлөл, төсөл хэрэгжүүлэх нэгж, төсөлд хамрагдсан 4 сумын ногоочид оролцлоо.

Азийн хөгжлийн банкнаас ХХААХҮЯ-тай хамтран хэрэгжүүлж буй “Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуйг эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах 91-92 мон” төсөлд хамрагдаж буй ногоочдын ногоог Улаанбаатар хотод хадгалан, томоохон дэлгүүрүүдэд худалдан борлуулж, дэмжиж ажиллахаар 2020 оны 8 дугаар сарын 29-ний өдөр “Монлог” ХХК-ний захирал Б.Батмөнхтэй уулзалт хийж “Ургац Ерөө” хоршооны дарга Н.Баасансүрэнтэй гэрээ байгуулан ажиллахаар боллоо.

2020 оны 08 дугаар сарын 11-ний өдөр “Ерөө сумын 2-р багийн нутаг дэвсгэр “Баянгол” гэх газар ургамал түүж байна” гэсэн иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээллийн дагуу тухайн газарт очиж хяналт шалгалт хийхэд “Хөвсгөл их тайга” ХХК нь “Төмсний хөндий ам” гэх газар 2 гэр, 1 майхан, 20 гаруй хүний бүрэлдэхүүнтэй хус модны навч түүж хатаан бэлтгэж байсныг, мөн Улаан даваан голын урд “Хөвсгөл их тайга” ХХК нь 6 майхан, 30 гаруй хүний бүрэлдэхүүнтэй

бичиг баримтын бүрдэлт хууль бусаар ургамал түүн, үйл ажиллагаа явуулж байсныг таслан зогсоож хариуцлага тооцож ажиллалаа.

Шимэгчдэх өвчнөөс урьдчилан сэргийлэх үүднээс мал угаалгын ажлыг сумын хэмжээнд зохион байгуулж, нийт 44430 мал амьтан угаалганд хамрагдсан. Угаалгын явц, хяналт шалгалтыг мал эмнэлгийн тасаг 3 удаа хийж, малчдад угаалгын ач холбогдолыг танилцуулан угаалганд идэвхитэй хамрагдахыг зөвлөн ажилласан. Мөн Бугант тосгоны “Бадаанзүрх” МЭҮНэгжийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний явц гүйцэтгэлтэй танилцан, малчидтай уулзаж мал эмнэлгийн хуулийн зөвлөгөө, урьдчилан сэргийлэлт хийхийн ач холбогдлын тухай мэдээлэл, зөвлөгөөн хийж Ходоод, Дөхөм, Баянголын 2432 үхэрт Боом, Дуут хавдраас урьдчилан сэргийлэх вакцин, 1645 хонинд Боомоос урьдчилан сэргийлэх вакциныг хийж гүйцэтгэлээ.

2020 оны 8 сарын 1-3-ны өдрүүдэд Ардын хувьсгалын 100 жилийн ойн баярыг угтаж “Бид Партизаны үрсэд” Ерөө бүсийн ахмадуудын спорт, урлагийн бага наадамд ахмадуудын мэндчилгээ, урлагийн тоглолтыг Соёлын төвөөс бэлтгэн оролцсон.

“Хоеумег стар” клубын Дархан-Уул аймаг дахь салбарын дасгалжуулагч О.Жанат 2 ээлжээр “Волейбол”-ын секц хичээллүүлж, Ерөө сумаас 26 хүүхэд, Дархан-Уул аймгаас 11 нийт 37 сурагч хамрагдлаа.

Сумын 1-р багийн иргэн Ш.Ариунзаяагийн санаачилсан “Тэгш боломж-Ерөө” хүүхдийн тоглоомын талбай засварлах хандивын аяныг дэмжиж хамтран ажиллаж Гангын тохой хэсгийн хуучин тоглоомын талбайг засварлан нийт 1.146.220 төгрөг зарцууллаа.

Жавхлант сум:

8 дугаар сард Засаг даргын зөвлөлийн хурал 1, төр төсвийн байгууллагуудын дарга, эрхлэгч болон албан хаагчдын шуурхай хурал 4 удаа хуралдлаа.

Сумын Засаг даргын 2020 оны 01 дүгээр албан даалгавар, сумын Засаг даргын 2020 оны 2 дугаар сарын 14-ний өдөр баталсан “Хариуцлагатай эргүүл жижүүрийг томилон ажиллуулах тухай” А/21 тоот захирамжаар баталсан хуваарийн дагуу сумын албан байгууллагуудын албан хаагчид эргүүл жижүүрийн үүргийг гүйцэтгэн ажиллаж байна.

Орон нутгийн сонгууль болохтой холбогдуулан сумын сонгуулийн салбар хороо байгуулагдан ажиллаж байна.

Иргэдийн Төлөөлөгчдийн хурал хуралдаж сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны 4-н жилийн мөрийн хөтөлбөрийн биелэлтийг хэлэлцэн хангалттай сайн үнэллээ. Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүн биелэлтийн сэтгүүлийг гаргаж, сумын 700 өрхөд тарааж, сурталчилан таниулах ажлыг зохион байгуулан ажилласан.

“Тогтвортой амьжиргаа-3” төслийн баг 2019-2020 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын гүйцэтгэл, иргэдээс гарсан санал эрэмблэгдсэн ажлуудыг газар дээр нь үзэж хяналт үнэлгээ хийж ажиллалаа.

Улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй “Орон нутгийн зам хөдөлгөөний соёл”-д “Яараад яахав дээ” аяныг сумын хэмжээнд Сэлэнгэ аймгийн цагдаагийн газар, Эрүүл мэндийн төв, цагдаагийн албатай хамтран зохион байгуулж жолооч нарт замын хөдөлгөөнд соёлтой оролцохыг уриалж мэдэгдэл, сэрэмжлүүлэг өгч дархлаа дэмжих зорилгоор витамин тарааж ажиллалаа.

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээлийн шинэ жил эхлэхтэй холбогдуулан багш, ажилчид үйл ажиллагаагхангах, коронавируст халдвараас сэргийлэх журмын дагуу анги танхимд ариутгал цэвэрлэгээ хийж, багш ажилчид эрүүл мэндийн урьдчилсан шинжилгээнд бүрэн хамрагдсан.

Тус сумын Соёлын төвөөс “Байгаль эхээс соёл эхэлдэг” бүсийн соёлын ажилтнуудын нөхөрсөг уулзалт, JCI-ийн дархан дах салбарын залуустай хамтран “Өнгөлөг аялцаага” арга хэмжээ, Номад нейчур кемпийн арга хэмжээг Соёлын ажилчид, ардын авьяастан, дугуйлангийн сурагчдын хамтарсан Эсгий хийх зан үйл, СББӨвийн үзэсгэлэн, **“Монгол өв соёл мину ивент”** тоглолтыг зохион байгууллан ажилласан.

Сумын Засаг даргын 2020 оны 8-р сарын 14-ний өдрийн А/119 тоот захирамжын дагуу үр тариа, төмс, хүнсний ногооны ургац тогтоох ажлын хэсгийн бүрэлдэхүүн үр тариа, төмс, хүнсний ногоо тариалсан нийт талбайн урьдчилсан тогтоолтыг хийж ажилласан. Ургац тогтоолтын урьдчилсан дүнгээр 8410 га талбайд улаан буудай тариалсан нь ургац тогтоолтоор нэгж га талбайгаас 10 цн буюу 8400 тн төмс, хүнсний ногоо 210 га талбайд тариалалт хийж нэгж га талбайгаас 123 цн нийт 2572 тн ургац хураан авах урьдчилсан дүн гарсан байна.

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах, мал сүргийн тарга хүчийг сайтар авахуулж өвөл хаврыг эрсдэл багатай даван туулах зорилгоор УРИАЛГА боловсруулан малчид, мал бүхий иргэдэд цахимаар болон цаасаар хүргэн ажиллалаа.

Усархаг бороо ихээр орж голын усны түвшин нэмэгдэж, үерлэж байгаа учир голын ойролцоо ай сав газраар зусаж байгаа малчид болон иргэдэд гол уснаас болгоомжлох, үерийн аюулаас сэрэмжлэн өөрийн аюулгүй байдлаа ханган нүүх мэдэгдлийг 65 айл өрхөд өгч ажилласан.

08 дугаар сарын 12-ны өдөр Моностой 2-р багийн иргэн А.Чадраа үерт орсон гэх дуудлагын дагуу сумын онцгой комисс 12 хүний бүрэлдэхүүнтэй сумын онцгой комисс, Аймгийн онцгой байдлын алба дуудлагын дагуу очиж усанд боогдсон 3 иргэнийг Онцгой байдлын аврах анги завиар гарган аврах ажиллагааг зохион байгууллаа.

Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг 581 хүнд үзүүлж зөвлөгөө өгч ажиллалаа.

- Амбулаторийн үзлэгээр- 195
- Урьдчилан сэргийлэх үзлэг - 250
- Идэвхитэй хяналтаар - 25
- Гэрийн идэвхитэй эргэлтээр- 111

Зүүнбүрэн сум:

“Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд сумын Засаг даргын 2020 оны А/151 тоот захирамжийн дагуу малчин, мал бүхий 213 иргэн, 2 аж ахуй нэгж

байгууллагатай 2500 га газарт байгалийн хадлан ашиглуулах гурвалсан гэрээг байгуулан ажиллалаа.

Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21,2,21,3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2020 оны А/110 тоот “Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах тухай” захирамжийн дагуу мал, амьтны гоц халдварт, халдварт шимэгчтэх өвчин гарах, тархахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор малын угаалга болон ариутгал халдваргүйтгэлийн арга хэмжээг технологит хугацаанд зохион байгуулж, нийт 168710 толгой мал хамруулахаас “Оюут Сүрэг” МЭҮН 49 өрхийн 18306 толгой бог, “Энх бүрэн сүрэг” МЭҮН 76 өрхийн 3261 толгой бог, 26 өрхийн 1007 толгой бод малыг угаалганд хамруулж, 16 өрхийн 3645мкв хашаа хороонд ариутгал халдваргүйжүүлэлт хийж хэрэгжилтийг мал эмнэлгийн нэгдсэн цахим мэдээллийн санд бүртгэлээ.

Сумын Засаг даргын 2020 оны А/150 тоот захирамжийн дагуу Бэлчээрийн газрын даацыг фото мониторингийн аргаар тодорхойлох ажлын 8 дугаар сарын 10-12 ны өдрүүдэд зохион байгуулж бэлчээрийн газрын 10 цэгт судалгааг хийж гүйцэтгэлээ.

Геодези, зураг зүйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 8 дахь зүйл, 10.4, 11.1 дэх заалт, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2020 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 01/509 тоот албан даалгаврын дагуу “Нутаг дэвсгэр дэх геодезийн байнгын цэг тэмдэгтийн тооллого явуулах ажлыг зохион байгуулан 33 цэгт хяналт тавин ажиллалаа.

Сумын төр, төсвийн байгууллагуудын санхүүгийн анхан шатны баримтыг хянан шалгаж, Санхүүгийн удирдлагыг мэдээллээр хангах системд давхардсан тоогоор 1124 байгууллагын 1,291,866,44 төгрөгийн гүйлгээг шивж орууллаа.

2020 оны өдөр тутмын мемориалын баримтыг тулган шалгаж, 585 мемориалын баримтыг баталгаажуулан, 3 боть 1056 байгууллагын 1.081.087.654 төгрөгийн хадгаламжийн нэгжийг архивлан үдлээ.

Хөдөлмөр эрхлэлтийн Limis програмд ажилгүй 16 иргэнийг бүртгэж, шинэ ажлын байранд 15, зуучлалаар 21 иргэнийг ажлын байртай болгож ажиллаа.

Мандал сум:

Хүүхдийн өөрийн сонирхол, оролцоонд тулгуурлан, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, өөрийн чадвараа нээн илрүүлж, хөгжүүлэх, сурлагын амжилтаа дээшлүүлэх нөхцөл боломжоор хангах зорилготой 5 төрлийн дугуйлан хичээллэж байна.

Аймгийн нэр /хүүхдийн ордон, хөгжлийн төвийн нэр/	Нэршил /дугуйлан/	Хамрагдсан хүүхдийн тоо					Хүйс		Нийт хамрагдсан хүүхдийн тоо
		3-6 нас	6-11 нас	11-14 нас	14-18 нас	Нийт	Эр	Эм	
Зүүнхараа Хүүхдийн ордон	Шатар	10	32	9		51	19	32	163

Сэлэнгэ аймгийн Мандал сумын төвийн гол гудамж замуудын 6,5 км хатуу хучилттай авто зам, 12,5 км явган зам баригдаж ашиглалтад орлоо.

“Алтан үндэс кострактн” ХХК нь трассын дагуу 5,3 км бохирын шугамын ажлыг 5 км шугам угсарч суурилуулаад байна.

Дархан-Улаанбаатарын замаас Сэлэнгэ аймгийн Мандал сум хүртэлх 28,9 км хатуу хучилттай авто замын гүйцэтгэл 90 хувьтай явагдаж байна.

Жишиг гудамж байгуулах зорилгын хүрээнд Сансарын гудамжинд 0.77 км бетон хучилттай авто болон явган зам барих ажил 80 хувийн гүйцэтгэлтэй буюу 0.62 км зам баригдаад байна.

Төмөр замчдын 1-р багийн Вокзалын гудамжинд 1, Сургуулийн гудамжинд 2, нийт 3 худгийн барилга шинээр барьж, ухаалаг худгийн систем суурилууллаа.

Төмөрзамчдын 1-р багийн Баруун-Өлөнтийн гудамжинд 1, Ширхэнцэгийн 2-р багийн Хайлаастын гудамжинд 1гүний худаг гаргаж, ухаалаг худгийн систем суурилууллаа.

СББХХК-ны орон сууцны гадна талбайн тохижилтын ажлын гүйцэтгэл 80 хувьтай байна. Тус талбайд стандарт мини хөл бөмбөгийн талбай, сагсан бөмбөгийн талбай, элсний гар бөмбөгийн талбайнуудыг байгууллаа.

Түнхэл тосгоны сургуулийн барилгын их засвар 62 хувьтай, 1-р цэцэрлэгийн засвар 70 хувьтай, Хэрх цэцэрлэгийн засвар 65 хувьтай, Мөнгөнхараа чуулгын гадна фасад засвар 50 хувьтай, спорт, сургалтын цогцолборын барилгын их засвар 30 хувьтай байна.

Түнхэл цэцэрлэгийн хуучин барилгын дотор хана, тааз, шалыг засварлаж, халаалтын төв шугамд холболоо.

Хүүхэд залуучуудын соёл спортын цогцолбор төвийн барилгын 4 ширхэг блокыг барьж ашиглалтад орууллаа.

Түнхэл тосгоны 10 ортой эрүүл мэндийн төвийн барилгын ажил 95 хувьтай байна.

Баян суудалын 3-р багт, Хөгжилийн 5-р хэсэгт сагсан бөмбөгийн стандарт талбайг ашиглалтад орууллаа.

Асахгүй байсан нийт 9 гудамжны 164 ширхэг гэрэлтүүлгийн толгойг сольж, 2, 3, 7, 9-р багуудад 115 ширхэг 100 ваттын чадалтай, тусгал сайтай гэрэлтүүлэг шинээр суурилууллаа.

Сумын хэмжээнд 6862 га талбайд улаан буудай тариалснаас 241 га талбай тэжээлд шилжиж 7767 тн улаанбуудай, Малын тэжээл 614 га-с 737 тн, рапс 453 га-с 544 тн, төмс хүнсний ногооны баланс гаргахад 739 га-с 6100тн төмс, 528 га-с 6458 тн хүнсний ногоо хурааж авах төлөвтэй байна.

Төмс хүнсний ногоо Улаанбаатар болон бусад аймаг суманд худалдаалах ногооны гарал үүслийг 3-н ААНБ, 58 иргэнд олгож, сумын төмс хүнсний ногоочдын өргөдлийн дагуу Сумын засаг дарга Улаанбаатар хотын Чингэлтэй дүүрэгт хамтран ажиллах хүсэлт явуулж 9-р сарын 11-ний өдрөөс 10-р сарын 01-ний өдрийг хүртэл Тэнгис кино театрын талбайд үзэсгэлэн худалдаа гаргаж 20 ногоочин оролцохоор боллоо.

Сумын нутаг дэвсгэрт тухайн жилд ашиглаж болох хадлангийн талбайн хэмжээг урьдчилан тогтоож, хуваарилах ажлын хүрээд 8-р сарын 15-ны өдрөөс 67 малчин өрхийн 1500 га хадлангийн талбайн гэрээг байлууллаа.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын А/223 тоот бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга, сорил шинжилгээ хийх тухай захирамжийн дагуу тугал 200, хурга 500, ишиг 600 нийт 1300 тал малыг хамрагдсан.

Паразит өвчнөөс сэргийлэх угаалганд 61580 толгой малыг хамруулсан. Сэлэнгэ аймгийн мал эмнэлгийн хэлтэс, улсын мал эмнэлэг ариун цэврийн лабораторийн мэргэжилтнүүдтэй хамтран шүлхий, боом өвчний тандалт 12 өрхийн 450 толгой малаас дээж авлаа.

Талбай тусгаарлалт хийлгэх 4 ААНБ хүсэлт гаргасны дагуу 4 ААНБ-д үйлдвэрлэлийн огтлолтоор 27 га, арчилгааны огтлолтоор 13 га, цэвэрлэгээний огтлолтоор 125 га нийт 165 га талбайд мод бэлтгэлийн талбай тусгаарлалтын ажил хийгдлээ. Хэрэглээний мод бэлтгэх эрхийн бичгийг 11 ААНБ, 6 нөхөрлөлд 937,32м3 хэрэглээ, 368,73 м3 түлээ олгож, 66 ширхэг гарал үүслийн гэрчилгээнд хэрэглээ 1015,1м3, түлээ 375 м3 нийт 1390,1 м3 бичиж олголоо.

Сэлэнгэ аймгийн Байгаль орчин, Аялал жуулчлалын газрын Ойн албаны мэргэжилтэн нар Мандал суманд мод бэлтгэлийн үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаа, бичиг баримт, мод бэлтгэлийн талбайд төлөвлөгөөт хяналт шалгалтыг 5 хоног зохион байгууллаа.

Орхон сум:

Covid-19 халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэн цахим орчинд **Orkhon Sum Zdtg Selenge** Facebook хаяг /3.7к дагагчтай/, Орхон сум ЗДТГ/1.7к дагагчтай/, Сэлэнгэ аймаг Орхон сум групп /3.2к дагагчтай/, Нарт Орхоны хүүхдүүд /2.2к дагагчтай/, SelengeorhonEmtбүртгэлтэй хаягуудаар мэдээлэл, сурталчилгаа, зөвлөмж, Улс, аймаг, сумын Онцгой комиссын шийдвэрүүдийг хүргэх ажлыг тогтмол зохион байгуулж байна.

Сумын Гамшгаас хамгаалах штабын жижүүрүүд төр төсвийн байгууллагын хариуцлагатай эргүүл жижүүрээс цаг үеийн мэдээ тайланг авч аймгийн Онцгой байдлын газарт 9:00, 18:00 цагуудад, аймгийн ЗДТГ-ын 70363684 утсанд 9:00, 18:00, цагуудад, аймгийн МХГ-ын 70363608 утсанд 9:00, 11:00, 13:00, 17:00, 21:00, цагуудад цаг үеийн мэдээ тайланг өгч Selengemhg2020s@gmail.com, emer.selenge@yahoo.com хаягаар тус тус илтгэх хуудсаар хүргүүлж ажилласан. /Илтгэх хуудсуудыг баталгаажуулан сар сараар болгон үдэж архивын нэгж үүсгэсэн./

“COVID-19 халдвараас хамтдаа сэргийлье!!!” “Амны хаалтаатогтмол зүүж хэвшин, өөрийгөө болон хайртай хүмүүсээ хамгаалъя!!!” Challenge–үүдийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулж ажилласан.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/220 тоот захирамжийн хэрэгжилтийг ханган 08-р сарын 31-ний өдрийг хүртэл сумын гамшгаас хамгаалах штаб хуваарийн дагуу аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газарт цаг үеийн мэдээ тайланг өгч ажиллаж байна.

2020-2021 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд 2020 оны 08-р сарын 20-21-ний өдрүүдэд иргэдтэй хадлангийн газрын гэрээ байгуулж, 08-р сарын 24-28-ны өдрүүдэд хадлангийн газрын хувиарлалтыг хийн ажиллаж байна.

ХАА-н тасгийн дарга, газрын даамал, 2-р багийн Засаг даргатай хамтран ургац тогтоолтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 149 тоот тогтоолоор тус суманд 150 м.куб хус, 150 м.куб улиас мод бэлтгэх хуваарийн дагуу Баруунбүрэн сумын Сум дундын ой ангийн инженер Н.Энхтөртэй хамтран тус сумын 2-р баг Хар нүдэн, Таван доржийн аманд мод бэлтгэх талбай тусгаарлалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Орхонтуул сумын харъяат иргэн Маамуу нь Орхон сумын 1-р багийн нутагт зөвшөөрөлгүй бууж бэлчээр ашигласан зөрчилд Зөрчлийн тухай хуулийн дагуу торгуулийн арга хэмжээ тооцсон.

Сумын хэмжээнд нийт 13406,1 га талбайд тариалалт хийснээс улаан буудай 9845 га, овъёос 146 га, ногоон тэжээл 680 га, тосны ургамал 2146 га, төмс 340 га, хүнсний ногоо 249,1 га талбайд тус тус тариалсан. Ургац тогтоолтын урьдчилсан балансаар улаан буудайн 117,8 га талбай, тосны ургамлын 20 га талбай малын тэжээлд шилжиж хураах боломжгүй болсон байна. Нийт хураах талбайн улаан буудай 9727,2 га талбайгаас 12139,2 тн ургац, 12,4 цн, тосны ургамал 2126 га талбайгаас 113,6 тн, га-ийн ургац 5 цн, овъёос 146 га талбайгаас 189,8 тн, га-ийн ургац 13 цн, төмс 340 га талбайгаас 4202 тн, га-ийн ургац 120,3 цн, хүнсний ногоо 244,1 га талбайгаас 2955,5 тн, га-ийн ургац 120,1 цн-ээр тус тус тогтоогоод байна.

Мал эмнэлгийн нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах тухай аймгийн Засаг даргын А/110 тоот, сумын Засаг даргын А/69 тоот захирамж дархлаажуулалт, угаалга, туулгалт, боловсруулалтанд сумын хэмжээнд мал амьтныг бүрэн хамруулах зорилгоор МЭТ, МЭҮН-д 2020 оны вакцин туугалтын ажлыг зохион байгуулж аймгийн МЭГ-т хүргүүлээд байна. Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Бүрэн-Орхон” ХХК мал эмнэлэг нь 2067 бод, 49002 хонь, 50874 ямааг угаалганд хамруулаад байна. Эгдэм БГБНХ мал эмнэлэг нь 2278 бод, 9961 ямаа, 11337 хонь угаалганд хамруулаад байна. Мал амьтны гарал үүслийн гэрчилгээг Бүрэн-орхон ХХК мал эмнэлэг нь адуу-8, үхэр-41, хонь-82, ямаа-60, үхрийн мах-611кг, хонины мах-355кг, ямааны мах-26кг, ЭГДЭМ БГБХН мал эмнэлэг нь адуу-13, үхэр-63, хонь-123, ямаа-88, адууны мах-342кг, үхрийн мах-1100кг, хонины мах-530кг, ямааны мах-26кг гарал үүслийн гэрчилгээг хянаж баталгаажуулан олгосон байна.

Орон нутгийн байгууллагуудын төсвийн санхүүжилтийн зарцуулалтын гүйлгээг батлагдсан төсвийн дагуу анхан шатны баримтыг үндэслэн хийж нийт **47397935.25** төгрөгийн гүйлгээг хийсэн. 2020 оны төсвийн гүйцэтгэлийн 7 сарын мэдээг гаргаж /shilendans.gov.mn/ шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг байршуулсан.

Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор 2 удаагийн ажил арга хэмжээг зохион байгуулж, 17 удаагийн цахим сургалтыг явуулж, хандалт 78 байна. Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих ач холбогдлыг олон нийтэд таниулах болон жирэмсэн, хөхүүл, эхчүүд, эмэгтэйчүүдэд зөв таниулах талаар мэдээлэл олгоход зорилго оршино. Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих дэлхийн 7 хоногийг тэмдэглэн өнгөрүүлсэн.

Сайхан сум дахь гал түймэр унтраах, аврах 61-р ангид хүсэлт хүргүүлж, “Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах” сэдэвт сургалтанд эмч, эмнэлгийн 16 ажилчид хамрагдаж гал түймэр гарсан үед хэрхэн ажиллах талаарх мэдлэгтэй болсон.

Орхонтуул сум:

Өндөржүүлсэн бэлэн байдал зарлаж олон нийтийг хамарсан үйл ажиллагаа явуулахыг хязгаарласантай холбоотойгоор албан хаагчид цахимаар Зөрчил гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Гэр бүл-Хүүхэд хамгаалалын талаарх мэдээлэл зэргийг Орхонтуул ЗДТГ, Орхонтуул сумын вэб хуудас, захирагчийн албаны цахим хуудсанд байршуулан сурталчилан ажиллаж байна.

Цаг үетэй холбогдуулан Засаг даргын захирамж гарган иргэдийн эрүүл мэндийн хамгааллыг сайжруулах зорилгоор сумын хэмжээнд архи согтууруулах ундаагаар үйлчлэх газруудад цагийн хязгаар тогтоож, сумын төвөөс гарах, орох хөдөлгөөнийг түр хугацаагаар хязгаарлалт хийн сумын төвд цагдаагийн 2 пост , рашаант тосгонд 1 постыг тус тус ажлуулж захирамжийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж “Шинэ төрсөн хүүхэд, эхэд хүндэтгэл үүүлэх журам”-ыг тогтмолжуулан шинэ төрсөн 5 хүүхдэд хүндэтгэл үзүүлээ.

Сумын Хөдөлмөр эрхлэлтийн албанд ажил хайгчаар бүртгүүлтэй 3 иргэн төр төсвийн байгууллагад, аж ахуй нэгж байгууллагад 4 иргэн, гэрээт малчнаар 2 иргэнийг ажлын байранд зуучлан LMIS програмд бүртгээд байна.

Эрүүл мэндийн төвийн анхан шатны үзлэг шинжилгээнд нийт 752 үзлэг хийгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 85, амбулаторийн үзлэг 327, идэвхтэй хяналтаар 75, гэрийн эргэлт 148, дуудлага 92 үүнээс алсын дуудлага 7, гэрийн дуудлага 18 байна. Жирэмсний хяналтанд 35 эх хянагдаж байна. Артерийн гипертензия, чихрийн шижингийн эрт илрүүлэг үзлэгт 40-65 насны 75 хүнийг хамруулсан. “COVID-19” халдвараас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн мэдээлэл сургалт сурталчилгааг давхардсан тоогоор 28 байгууллага, 5450 хүнд хийж, худалдаа үйлчилгээ эрхлэн явуулдаг ААН, банкуудаар 3 удаа явж уг өвчний сэрэмжлүүлэг, санамж хуудас гарын авлага тараасан.

Сумын хэмжээнд мал амьтныг шимэгчлэх өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх зорилготой мал угаалгын нэгдсэн арга үргэлжлэн явагдаж байна. Одоогийн байдлаар нийт 16095 толгой мал хамрагдсан. Мөн бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтанд 997 тугал, 710 хурга, 509 ишиг нийт 2216 толгой төл хамрагдаад байна. Ноосны урамшуулалд хамрагдах 177 малчны ноосны падан болон холбогдох материалыг ХХААГазарт хүргүүлсэн.

2020 оны 08-р сарын 01-25-ны өдрийг хүртлэх хугацаанд тус сумын Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжилт авдаг 6 байгууллага болох сумын ЗДТГ, ИТХурал, 1-р сургууль, Соёлын төв, 1-р цэцэрлэг, Рашаант ЭМТөв зэрэг төсөвт байгууллагуудын үндсэн болон нэмэлт санхүүжилтийн данснаас 23100,0 төгрөгийн төлбөр тооцоог, анхан шатны бичиг баримтыг үндэслэн 39 төлбөрийн хүсэлтээр, 25 удаагийн хандалтаар ЗГУМС-д ажил гүйлгээг шивж баталгаажуулсан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулж шуурхай удирдлагаар ханган ажилласанаар төсөвт байгууллагуудын шилэн дансны мэдээлэл цаг хугацаандаа, үнэн зөв, бүрэн мэдээлэгдсэн.

Сайхан сум:

Улс орон даяар өрнөж буй “Орон нутгийн зам- Хөдөлгөөний соёл” нэгдсэн арга хэмжээ болон “Яараад яахав дээ” аяны хүрээнд зам тээврийн осол, хэргээс

урьдчилан сэргийлэх, чиглэлээр ажил зохион байгуулж, замын тэмдэг тэмдэглэгээ, хурд сааруулагчийг сайжруулах, нэмэгдүүлэх арга хэмжээ авч, Амарбаясгалант хийдэд Бумбаны тахилга болж байгаатай холбогдуулан төв замын ачаалал ихэссэн тул Сум дундын Цагдаагийн хэлтэстэй хамтарч, замын хөдөлгөөнд оролцогчдод Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай, Зөрчлийн тухай хуулиудыг сурталчлах, таниулах зорилгоор замын хөдөлгөөнд анхаарал болгоомжтой, соёлтой оролцох, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх тухай 2000 ширхэг санамж, сэрэмжлүүлэг, мөн Эрүүгийн хууль, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудаар гарын авлага бэлтгэн сумын аж ахуй нэгж байгууллага, иргэдэд тараан ажиллалаа.

Сайхан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 15 тоот албан бичгийн дагуу Хөтөл 1-р баг, Гавшгай 2-р багууд хамтран тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй ААН байгууллага болон иргэдэд үер усны аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг бүхий 100 ширхэг гарын авлага, санамж бэлтгэн, байршуулж, тараан ажиллалаа. Орон нутгийн цахим сүлжээ хаягийг ашиглан иргэдэд хууль, эрх зүйн мэдээ мэдээлэлийг нийтлэн хүргэж байна.

Сайхан сумын Монголын эмэгтэйчүүдийн холбооны салбар зөвлөлтэй хамтран “Эрүүл мэнд- Идэвхтэй” аяныг өрнүүлж 1-р сургуулийн Ц.Хонгорзул багштай 11а ангийн хүүхдүүд ЗДТГ-ын талбайд бүжиг, идэвхитэй дасгал хөдөлгөөн иргэдэд зааж Ковид -19 халдвараас урьдчилан сэргийлэх үүднээс иргэд болон хүүхдүүдийн биеийн халууныг халуун хэмжигч багажаар үзэж, гарын авлага, зөвлөмж, маск тараан ажиллав.

Сумын эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн нэгж нь 08-р сарын тайлангийн хугацаанд нийт 189 мэдүүлэг хүлээн авч, Монгол Улсын үндсэн хууль, Иргэний тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль болон бусад дээд шатны байгууллагын чиглэл заавар зөвлөмжийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж, Улсын бүртгэлийн үйлчилгээний хураамжийн дансанд 975,186 төгрөг, үл хөдлөх эд хөрөнгө худалдсанаас оруулсан татварын орлогод 1,950,000 төгрөг тус тус төвлөрүүлсэн байна.

Сант сум:

“Аймгийн Засаг даргын 2020 оны А/212 дугаар захирамжид нэмэлт өөрчлөлт оруулж, хугацаа сунгах, зарим газрын үйл ажиллагааг нээх тухай” А/220 дугаар захирамжийн дагуу сумын Засаг даргын захирамжаар гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 08-р сарын 31-ний өдрийг дуустал сунгаж, шуурхай штабын эргүүл жижүүрийн хуваарийг томилгоожуулж ажиллаж байна.

Сум хөгжүүлэх сангийн зөвлөл хуралдаж 8 иргэний төслийг хэлэлцэж, 8 иргэнд 54,0 сая төгрөгийн санхүүжилтийг олгохоор шийдвэрлэсэн.

Ургац хураалтын явцын мэдээгээр сумын хэмжээнд 14,8 га талбайгаас 8 төрлийн 63,4 тн хүнсний ногоо хураан аваад байна.

“Үндэсний боловсруулах үйлдвэрт хонины ноос бэлтгэн тушаасан малчин, мал бүхий иргэнд мөнгөн урамшуулал олгох журам”-ын дагуу 2020 онд дотоодын үйлдвэрүүдэд хонины ноос тушаасан 126 өрхийн 21.5 тонн ноосонд мөнгөн

урамшуулал олгуулахаар материалыг бүрдүүлэн аймгийн ХХААГазарт хүргүүлээд байна.

Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд 136 иргэнд 574 м.куб түлээ, хэрэглээний зориулалтаар 125 иргэнд 695 м.куб модны эрхийн бичиг олгож 4.353.563төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлсэн байна. Сумын хэмжээнд иргэдийн түлшний хангамж 60 хувьтай хангагдаж байна.

Ойн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж 2 удаагийн эргүүлээр хууль бусаар самар түүхийг завдсан 3 машин 14 иргэдийг уулнаас албадан буулгалаа.

Улсын Онцгой комиссын 2020 оны 08-р сарын 07-ны өдрийн “Хичээл сургалтын үйл ажиллагааг эхлүүлэх зарим арга хэмжээний тухай” 02 дугаар албан даалгаврын хүрээнд 2020 оны 08-р сарын 14-ний өдөр сумын ЕБС, 1-р цэцэрлэг “Мөнх Ариун Сэлэнгэ” ХХК-иар 3961м.кв талбайд ариутгал халдваргүйжүүлэлтийг хийлгэж, мэргэжлийн байгууллагаар сургууль, цэцэрлэгийн ундны усанд хими, нян судлалын шинжилгээг өгөөд байна. Мөн багш ажилчид эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдсан ба ямар нэгэн халдварт өвчлөлтэй багш ажилтан байхгүй.

2020-2021 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 99 хүүхэд, ерөнхий боловсролын сургуульд 309 хүүхэд хамрагдан суралцаж байна. Үүнээс 1-р ангид 30 сурагч элсэн орж байна.

“Дэлхийн зөн” ОУБ-аас бүртгэлтэй 6 настай /энэ жил 1-р ангид элсэн суралцах/ болон нэр заагдсан 49 хүүхдэд сурагчийн цүнх, дагалдах хэрэгслийн хамт олгосон байна.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх эрүүл ахуйн зан үйлийн талаар сурталчилгаа, нөлөөлөлийн ажлыг зохион байгуулж орон нутгийн мэдээллийн цахим групп хаягт 9 удаагийн мэдээлэл байршуулсан.

Соёлын төвийн дээврийн сольсон төмрийг иргэдэд үнэ тогтоон борлуулж, Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд 3201,4 төгрөгийг төвлөрүүлэн зарцуулах эрх нээлгэн ахмадын байрны дулаан, усны шугам татахад 1500,0 төгрөгийг зарцуулаад байна.

2020 оны 8-р сарын 26-ны өдрийн байдлаар орон нутгийн татварын орлого /өссөн дүнгээр/ 30422,2 төгрөг төвлөрөхөөс 39459,8 төгрөг төвлөрч орлогын гүйцэтгэл 129,7 хувьтай байна.

Сүхбаатар сум:

Сумын Засаг даргын орлогч даргын баталсан “Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах” удирдамжийн дагуу МСҮТ, ЕБСургууль, цэцэрлэгүүдэд хяналт шалгалт хийж, заавар зөвлөгөө өгч ажиллаж байна.

Тус сард сумын Засаг даргын Тамгын газарт нийт 41 албан тоот ирсэн байна. Иргэдээс 14 өргөдөл ирсэн шийдвэрлэх шатандаа байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны 02 тоот албан даалгавар, Улсын онцгой комиссын 2020 оны 02 тоот албан даалгаврын дагуу сургууль, цэцэрлэгийн хичээлийн шинэ жилийн бэлтгэл хангалт, өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд сургууль цэцэрлэгийн захирал эрхлэгч нарын уулзалтыг 2020 оны 08-р сарын 24-ний өдөр зохион байгууллаа. Уулзалт сургууль, цэцэрлэгийн 16 захирал, эрхлэгч хамрагдлаа. Захирал, эрхлэгч нартай урсгал засварын явц, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, багшийн хангалт, анги танхимын хүрэлцээ, сурах

бичгийн нийлүүлэлт болон цэцэрлэг, сургуулийн хүүхдүүдийн бүртгэлийн ажил хэрхэн явагдаж байгаа, хичээллэхэд тулгамдаж байгаа асуудлаар санал солилцлоо. Сургууль цэцэрлэгээс гарсан ажлын мэдээлэл, саналыг нэгтгэн Засаг даргын орлогч, мөн ЗДТГ-ын дарга нарт танилцуулж, шаардлагатай сургууль цэцэрлэгтийн үйл ажиллагааг газар дээр нь үзэж, зарим сургууль цэцэрлэгт хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлын явц ариутгал халдваргүйтгэлийн гүйцэтгэлтэй танилцлаа.

2020-2021 оны хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлыг хангуулах, ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль 2020 оны 09-р сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан МХГ-аас зохион байгуулсан онлайн сургалтанд ЕБС-ийн 7 сургуулийн захирал, СӨБ-ийн 7 цэцэрлэгийн эрхлэгчийг хамрууллаа.

МУ-ын Засгийн газрын 2014 оны 71-р тогтоолын дагуу төрөөс санхүүжүүлэн суралцах шинээр болон дэвшин суралцах оюутнуудын материалыг хянан, Засаг даргын дэмжлэг албан тоотыг БШУЯ-ны Сургалтын төрийн санд 16 хүүхдийн материал бүрдүүлэн хүргүүлээд байна.

Үрчлэлт хүссэн 2 иргэний материалыг хүлээн авч шийдвэрлэсэн.

Аймгийн мэргэжлийн хяналтын газартай хамтран ил задгай худалдаа, үйлчилгээ явуулж байсан 11 иргэнд “Ил задгай худалдаа эрхлэхгүй байх” захирамжийг танилцуулж, мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажиллалаа.

Ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийг бүртгэх, зөвлөгөө мэдээлэл өгөх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, ажилд зуучлах үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэж, 5 иргэнийг ажилд зуучиллаа. Мөн ажилгүй 24 иргэнийг ажил хайгч иргэний ХЗЗ-2 маягтын дагуу бүртгэж мэдээллийн санд оруулсан.

“Ажлын байрыг дэмжих” хөтөлбөрийн “Аж ахуй эрхлэлтийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд “Жижиг зээл”-д хамрагдах журмын дагуу дэмжигдсэн 10 төслийг Төрийн банкны сэлэнгэ салбарт хүргүүлсэн.

2020 онд шинээр 200 ажлын байр бий болгохоос тухайн сард 14 ажлын байр шинээр бий болсныг маягтын дагуу бүртгэж мэдээлсэн.

Мал өвөлжилтийн бэлтгэл ажилтай холбогдуулан хадлангийн техник хэрэгслийн бэлтгэл бэлэн байдал, Улсын тусгай хамгаалалттай газар, хилийн зурвас газар өвөлжиж, хаваржих малчин өрх, малын тооны судалгааг гарган Хүнс, Хөдөө аж ахуйн газарт хүргүүлсэн.

Мал сүргийг паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга, угаалгад 6000 толгой бог мал, 1000 толгой бод малыг, бруцеллёз, лейкоз өвчнөөс урьдчилан сэргийлэх тандалт шинжилгээнд хээлтүүлэгч 60, хээлтэгч 550 нийт 610 толгой малыг хамрууллаа.

Төмс, хүнсний ногооны ургац тогтоолтын урьдчилсан балансыг гарган ХХААГ-т хүргүүллээ.

Тариалалтын мэдээ ХАА-7 маягтыг программд шивж оруулсан.

ХАА-10 маягтыг 8 дугаар сарыг програмд шивж орууллаа.

Сүхбаатар суманд улс, аймаг, орон нутгийн хөрөнгөөр дараах ажлууд тендер зарлагдан ажлуудыг эхлүүлж, хяналт тавьж ажиллаж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр:

1. Баянханы 4-р багт тоглоомын талбай-28.0
2. Буур хээрийн 8-р багт тоглоомын талбай-28.0

3. Баянханы 5-р багт тоглоомын талбай-28.0

4. 5-р багт гэрлтүүлэг-7.648.0

Орон нутгийн хөрөнгөөр:

1. Сүхбаатар биет үсгэн хөшөө-38.0

2. Буурын голын тохижилт-20.0

Улсын болон аймгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа ажилуудыг хүлээн авах ажлын хэсэгт орж хамтарч ажиллаж байна.

Орон нутгийн өмчийн газарт зарлагдаж байгаа үнэлгээний хороонд орж ажиллаа.

Шилэн дансны www.shilendans.gov.mnсайтад Сүхбаатар сумын төсвийн 08 сарын мэдээг, ОНХСангийн програмд 8-р сарын гүйцэтгэлийг тус тус оруулан ажиллалаа.

Түшиг сум:

2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 3, аймгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх зам засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог ажил тус бүрээр байгуулан тендерийн сонгон шалгаруулалтын ажлыг зарлан ажиллаж байна.

Шинэ төрлийн коронавирусээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд сумын Онцгой комисс, шуурхай штабыг тогтмол ажиллуулж, Засаг даргын Тамгын газрын байр, техник хэрэгслийг зориулалтын ариутгалын бодисоор халдваргүйтгэл, цэвэрлэгээг өдөр бүр хийж байна. Үйлчилүүлж буй иргэдийн халууныг тогтол хэмжиж, тэмдэглэгээ хийж байна. Коронавирусээс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг худалдаа, үйлчилгээний газруудын мэдээллийн самбарт байршуулж, дотоодын сургалтыг 2 удаа зохион байгууллаа. Давхардсан тоогоор төрийн болон төрийн бус, худалдаа үйлчилгээ, нийтийн тээврийн унаанд ариутгал халдваргүйтгэлийн ажлыг хийлээ.

Эрүүл мэндийн төвд 26 хүнийг хэвтэн эмчлүүлж, нарийн мэргэжлийн эмчийн хяналтанд 2 эхийг шилжүүлэн төрүүлж, жирэмсний хяналтанд 2 эхийг шинээр авч, одоогийн байдлаар жирэмсний хяналтанд 19 эх байна. Осол гэмтлийн тохиолдол 5 бүртгэгдсэн. Алсын 12, ойрын 43 дуудлагад үйлчиллээ.

Артерын гипертензи 45, чихрийн шижин-хэв шинж 2, элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 61 хүнийг хамруулж, товлолт дархлаажуулалтанд 36 хүн/тун хийж, дархлаажуулалтын дараах урвал гараагүй.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар “Мед буян” ХХК-иас 10 төрлийн тоног төхөөрөмж хүлээн авлаа.

2020-2021 оны хичээлийн шинэ жилийн бэлтгэл байдлыг хангах ажлын хүрээнд хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд оролцогч тогооч 2, бага боловсролын багш 7, дотуур байрны багш 1, сургалтын менежер 1, эмч 1 нийт 12 багш ажилчид эрүүл мэндийн үзлэгт хамрагдлаа.

Аймгийн Боловсрол, соёл урлагийн газраас зохион байгуулсан “2020-2021 оны хичээлийн жилийн бэлтгэл ажил, анхаарах асуудал” сургалтад сургуулийн захирал, сургалтын менежер 2, эмч 1 хамрагдлаа.

Сургуулийн гал тогооны хоолны заал, хоол бэлтгэлийн өрөөнд их засварын ажлыг хийлгэн үйл ажиллагаа явуулахад бэлэн болсон.

Хушаат сум:

Төрийн үйлчилгээний операторын системийн үйл ажиллагаа хэрэгжиж 7,8 саруудад иргэний үнэмлэхний лавлагаа, НДМ төлөлтийн талаархи тодорхойлолт, оршин суугаа хаягийн лавлагаа, жолоочийн лавлагаа зэрэг 6 төрлийн үйлчилгээг нийт 20 хүнд үзүүлж гаргасан хүсэлтийг шийдвэрлэн ажиллалаа.

Нийгмийн даатгал болон Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиудын шинэчилэлтээр 2020 оны 08-р сарын 28 хүртэл 586 хүнд зөвлөгөө өгч, нийгмийн даатгалд болон эрүүл мэндийн даатгалд малчид, ХХЭ, ажилгүй иргэдийг сайн дурын даатгалд хамрагдах талаар танилцуулан ажиллаж тараах материал болон гарын авлагыг 203 хүнд тарааж ажилласан. Шинээр тэтгэвэр тогтоолгох 34 хүний материалыг бодож баталгаажуулан олгосон. Тэтгэвэр тогтоолгох талаар зөвлөгөөг 196 хүнд, ЭМД, НД-д сайн дураар даатгуулах зөвлөгөөг 586 хүнд өгч үйлчилсэн.

2020-2021 оны хичээлийн шинэ жилийн бэлтгэл байдлыг хангах ажлын хүрээнд сумын ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын багш ажилчид байгууллагынхаа гадна, дотор засвар үйлчилгээг хийж, бүх анги танхимыг “Мөнх ариун Сэлэнгэ” ХХК-иарариутгал, халдваргүйтгэлийн ажлыг хийлгэж, ундны усны дээжийг шинжилгээнд хамруулан ажилласан.

Сэлэнгэ аймгийн БСГ-аасерөнхий боловсролын сургууль, сургуулийг өмнөх боловсролын захирал, эрхлэгч, арга зүйч, нийгмийн ажилтан, сургалтын менежер нарын сургалтыг Сант сумандзохион байгуулсан ба албан хаагчдыгбүрэн хамрагдсан. МөнБШУЯамнаас бүх сургууль, цэцэрлэгүүдийн багш нарт теле сургалтыг зохион байгуулж сургууль, цэцэрлэгийн багш, эрхлэгч, арга зүйч нар хамрагдсан. Хичээл, үйл ажиллагаанд хэрэглэх 5ширхэг компьютерийг хүлээлгэн өгсөн.

Багш нар хичээлийн үйл ажиллагаанд бэлтгэн БШУСайдын А/17 тушаалын дагуу төлөвлөгөө гарган, эцэг эх асран хамгаалагч нарт зөвлөгөө, зөвлөмж чиглэл хүргүүлж, хүүхэд хоорондын зай барих тэмдэг тэмдэглэгээг хийж ажиллаж байна. Бүх багш ажилчид үзлэг, шинжилгээнд бүрэн хамрагдаж, хичээлэхлэхэд бэлэн болсон.

9-р сарын 10-ны өдөр зохион байгууллагдах “Нэг залуу-Нэг санаачлага” уриан дор Залуучуудын хөгжлийн сарын аяны хүрээнд төлөөлөх манлайлагч залууг элчээр тодруулахаар тус сумын соёлын төвийн хөгжмийн багш Б.Алтаншагайд санал хүргүүлсэн.

Ургацын баланс тогтоох ажлын хэсэг 2 хоногт сумын хэмжээний үр тариа тариалсан тариалангын талбай, хадлангын газрын ургац тогтоолтоор ажилласан.

08-р сарын 23-ны өдөр орсон хүчтэй аадар бороо болон 1,4-н голчтой мөндөрт цохиулсан ААН, иргэдийн мэдээг аван нэгтгэж, Сэлэнгэ аймгийн ХХААГазар хүргүүлж ажиллалаа. Үүнд: 1 иргэний гэр, 4 аж ахуй нэгжийн талбай, 7 иргэний ногоон тэжээл болон төмс хүнсний ногооны талбай хамрагдсан.

2 иргэний ногооны талбайд мал орсон учир ажлын хэсэг явж хохирлыг тогтоож 2 тал харилцан тохиролцож хэргийг шийдвэрлэсэн.

Хүдэр сум:

Сумын Засаг даргын тамгын газрын хурал 1 удаа хуралдаж, цаг үетэй холбоотой асуудлуудыг хэлэлцэж хугацаатай үүрэг даалгаваруудыг өгч ажиллаа.

- Аймгийн арслан Д.Төрболдын наадам зохион байгуулах, аж ахуйн нэгжээс хандив тусламж хүсэх тухай
- Сумын хогийн цэгийн гадна талбайд асгасан хогийг түрэх, зайлуулах
- Сургуулийн спорт заалны засвар үйлчилгээ болон эрүүл мэндийн төвийн барилгын ажилд хяналт тавьж ажиллах
- Сумын өвөлжилтийн бэлтгэл ажил хангуулах тухай
- Ойгоос мод бэлтгэх үйл ажиллагаа эхэлсэнтэй холбоотойгоор хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх, хяналт шалгалтыг эрчимжүүлэх зэрэг ажлыг холбогдох албан хаагчдад үүрэг өгч шийдвэрлэж ажиллаж байна.

Хүдэр сумын ИТХ-ын тогтоол, Сумын Засаг даргын 2020.07.08-ны өдрийн А/113 “Хяналтын цэг ажиллуулах тухай” захирамжийн хүрээнд хяналтын постоор дамжин өнгөрөх тээврийн хэрэгсэл бүрээс хог хаягдлын тухай хуульд заасны дагуу хог үүсгэсний хураамж авахаар пост ажиллуулж 700,000 мянган төгрөг төвлөрөөд байна.

Орон нутгийн орлогын төлөвлөгөө 8-р сарын байдлаар 19,938,6 мян төгрөг батлагдсанаас 23,108,9 мянган төгрөг орж орлогын төлөвлөгөө өссөн дүнгээр 115,9 хувиар биелэсэн дүнтэй байна.2020 онд батлагдсан төлөвлөгөөт зардлыг зориулалтын дагуу зарцуулж ажиллаа.

Ковид-19 вирустэй холбоотойгоор ариутгал халдваргүйжүүлэлтийн зардал-290,0 мянган төгрөг зарцуулагдлаа. 2020 оны 8-р сарын байдлаар 6 иргэнээс зээлийн хүү, алданги тооцож 590,0 мянган төгрөг, 13 иргэнээс 7,820,0 мянган төгрөгний зээлийг барагдуулж ажиллаа.Одоогийн байдлаар сум хөгжүүлэх сангаас зээл олгоогүй байна.

Сумын ЭМТөв нь хүн амд эмнэлгийн тусламж үйлчилгээг стандартын дагуу чанартай үзүүлж, иргэдээс гомдол санал гаргалгүй ажиллаж байна.

Соёлын төвийн дотор заалны хуучирч, ховхорсон хананд эмульс,будаг хийж, хувцас солих өрөөнд засвар хийсэн.

Номын сангийн танхимаар 29 уншигч 74 номоор,тусгай бүлгийн 5 уншигч, 11ном, цахимаар 9 уншигч 13 ном захиалан нийт 42 уншигчид98 номоор үйлчилж ажиллалаа.

Аймгийн ХГБЗХГазраас “Хүүхэдтэй эерэг аргаар хүмүүжүүлье”, “Залуучуудын хөгжлийг дэмжих тухай” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. МөнХөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас хэрэгжиж буй “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ”төсөл хөтөлбөрийг сурталчилах өдөрлөг зохион байгуулж нийт 28 ахмад настан хамрагдсан.

Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлын хүрээнд сумын хэмжээнд нийт 7 цэгт ургамалын дээж авч, хэмжилт, боловсруулалтийг хийж ажиллалаа.

Монгол мал хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ноосны урамшуулалд хамрагдах 42 малчин өрхийн материалыг падааны хамт аймгийн ХАА-н газарт хүргүүлэн ажиллалаа.

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд хадлангийн талбайн ургац тогтоолтыг Цагаан нуга, Хүдрийн адаг, Төмөртэй, Мухар хөндий,Оросын булагтай, Шанд чиглэлд хийж, нөөцийн хадлан тэжээл бэлтгэх хүсэлтийг 08-р сарын 18-25-ны өдөр хүртэл хүлээн авч, 54 өргөдөл ирснээс ААН-10, 44 иргэн 4

байршлын 1550га талбайд хадлан бэлтгэхээр байна. Энэ тоон үзүүлэлт нь нийт хадлангийн талбайн 46 хувийг эзэлж байна.

Ажлын хэсгийн хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу сумын өвсний нөөцөд нийт 25 тн өвс нийлүүлэх үүднээс нэг ААН-150 боодол өвс, иргэн 50 боодол өвс нийлүүлэхээр тогтож гэрээг байгуулан ажиллахаар төлөвлөөд байна.

Өнөөдрийн байдлаар сумын хэмжээнд малчин мал бүхий 24 иргэн, нэг ААН хадлангаа бэлтгэж эхлээд байна. Үүнд нийт 200 тн хадлан бэлтгээд байна.

Сумын ургац хураалт, хадлан тэжээл бэлтгэлтэд ажиллах техникийн засварын ажлыг, мөн ургац хүлээн авах Үтрэм, зоорь, агуулахын засвар үйлчилгээ цэвэрлэгээг бүрэн хийж дуусгах мэдэгдэл ААН-дэд хүргүүлж уг ажил 90 хувьтай явж байна. Ургац тогтоолтын ажлын хэсэг га-аас авах ургацын хэмжээг 10 цн-ээр тогтоогоод байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/110 тоот, сумын Засаг даргын А/57 тоот “Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах тухай” захирамжуудын хэрэгжилтийг ханган ажиллаж, мал амьтны гоц халдварт, халдварт, шимэгчтэх өвчин гарах, тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор мал амьтны төлөвлөгөөт угаалгын ажлыг “Хүдэр Тохижилт” ОНӨААТҮГ-тай хамтран зохион байгуулж, бог малын угаалга 85, бодын угаалга 91, гахайн угаалга 100 хувьтай хамруулан ажиллалаа.

Засаг даргын 2019 оны малын механик өсөлтийг зогсоох тоо толгойг зүй зохистой харьцаанд байлгах, бэлчээрийн хомсдол үүсэхээс урьчилан сэргийлэх, зорилгоор гаднаас мал амьтан оруулж ирэх, мал амьтны шилжилт хөдөлгөөнийг хориглох захирамжийг ханган ажиллах ажлын хэсгийн хамт Булган аймгаас отор нүүдлээр орж ирсэн мал сүрэгт хяналт тавьж сумын нутаг дэвсгэрээс буцааж гаргах албадан арга хэмжээ зохион байгуулан, бод 180, бог 278 толгой малыг буцаан гаргаж ажиллалаа.

Сэлэнгэ аймгийн МХГ-ын даргын баталсан 2020.01.06-ны өдрийн 18\02 тоот “Хяналт шалгалт хийх тухай” байнгын удирдамжийн хүрээнд уул уурхайн хяналт шалгалтыг 2 удаа хийсэн. Сумын ИТХурлын 2020.01.24-ны өдрийн 152 тоот, 2020.06.29-ний өдрийн 165 тоот тогтоол, сумын Засаг даргын 2020.07.01-ний өдрийн А/75 “Ойгоос хэрэглээний болон түлээний мод бэлтгэх үйл ажиллагааг зохион байгуулах тухай” захирамжийн хүрээнд 3-р улиралд мод бэлтгэлийн талбай тусгаарлалт хийгдсэн Янгаахай, Хэрц, Галагтай, Шанд, Жаргалант чиглэлийн газруудад мод бэлтгэл болон мод тээвэрлэх хяналтын хуудас, Хөдөлмөр аюулгүй байдлыг ханган ажиллах талаар хяналт тавьж, заавар, зөвлөмж өгч ажиллаж байна.

Хүдэр суманд төмрийн хүдэр олборлох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Дархан төмөрлөг” ХХК нь 2020 оны байгаль хамгаалах төвлөгөөний дагуу дүйцүүлэн хамгаалах ажлаар Хүдэр сумын Баянцагаан 2-р багийн Цагаан зүрийн гол нэртэй газарт 15 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийхээр төлөвлөн ажиллаж байна. Уг ажлын хүрээнд 1 га талбайд техник болон биологийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэн төлөвлөгөөний ажиллаж байна. 2020 оны 07-р сарын 27-30 ны өдрүүдэд БОАЖЯ-ны Ойн албаны дарга Г.Цэнгэлзаяагаар ахлуулсан ажлын хэсэг мод бэлтгэлийн талбай тусгаарлалт

болон мод бэлтгэлийн гүйцэтгэлийн талаар хяналт шалгалтыг хамтран хийж ажиллалаа.

Цагааннуур сум:

Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан, уламжлал болгон зохион байгуулагддаг алслагдсан багийн иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх зорилготой “Төрийн үйлчилгээг-Иргэн бүрт” өдөрлөгийг 2020 оны 08-р сард Оргих 1-р багт халдвар хамгааллын дэглэмийг баримтлан зохион байгууллаа.

Нээлттэй нийгэм форумаас 6 хүний бүрэлдэхүүнтэй баг сумын эрх зүйн хөтчөөс зөвлөгөө, мэдээлэл авсан иргэдийн төлөөлөлтэй уулзалт, ярилцлага хийж, Иргэний танхимд байгуулагдсан Эрх зүйн хөтчийн булантай танилцлаа.

Иргэний бүртгэлийн чиглэлээр: Төрсний бүртгэл-13, Үрчлэлтийн бүртгэл-1, Эцэг тогтоолтын бүртгэл-1, Гэрлэсний бүртгэл-3, Нас барсны бүртгэл-4, Шилжин ирсний бүртгэл-8, Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл-18, Иргэний үнэмлэх дахин авах бүртгэл-2, Иргэний үнэмлэх олголтын бүртгэл -22, Лавлагаа олголт-18 хийгдлээ.

Тэтгэврийн даатгалын сангаас:

- 436 өндөр настанд -160 380,7 мян төгрөг
- 50 тэжээгчээ алдсан иргэнд -16 350,0 мян төгрөг
- 242 тахир дутуу иргэнд - 81 044,8,1 мян төгрөг
- 4 цэргийн өндөр настанд -2508.0 мян төгрөгийг

ҮОМШӨДаатгалын сангаас:

- 4 иргэнд 1417.6 мян төгрөг

Тэтгэмжийн даатгалын сангаас:

- Оршуулгын тэтгэмж 4 даатгуулагчид -4 000,0 мян/ төг

Ажилгүйдлийн даатгалын сангаас:

- 1 даатгуулагч-1 205,0 мян төгрөгийн тус тус олгоод байна.

Хүүхэд үрчлэлтийн материалыг хуулийн дагуу шалган, үрчлэлтийг хийж, захирамж гаргасан. Хүүхэд үрчлэлтийн талаар 3 иргэнд мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан.

Хичээлийн шинэ жил эхлэхтэй холбогдуулан боловсролын байгууллагуудад УОК, МХГ-аас ариутгал халдваргүйтгэл, эрүүл ахуйн талаар өгч буй албан даалгавар, зөвлөмж, мэдээллийг хүргэн хамтран ажиллаж байна.

Хүүхэд хамгааллын тухай хууль, гэр бүлийн тухай хууль, жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн талаарх мэдээллийг иргэдэд цахимаар хүргэж, нөлөөллийн ажил өрнүүлсэн.

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулдаг STYLE дэлгүүрийн хамт олонтой хамтран сумын зорилтот 1 өрхийн ЕБС-д сурдаг 2 хүүхдэд хичээлийн хувцас, хэрэгслийн туслалцаа үзүүлсэн.

Сумын татварын орлого 8-р сард 10486.3 мян/төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 08-р сарын 25-ны өдрийн байдлаар 9216.5 мян/төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 87.9 хувийн биелэлттэй байна. Төсвийн татварын орлогын бүрдүүлэлтэд хяналт тавьж ажиллаж байна. Өссөн гүйцэтгэлээр 186.6 %-ийн биелэлттэй байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын 8-р сарын санхүүжилт 100 хувь бүтэн ирсэн байна.

ОНХСангийн санхүүжилт 99225,7 мян.төгрөгийн санхүүжилт ирж 5000,0 мян.төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулах, шилэн дансны www.shilendans.gov.mnсайтад байршуулан, төсөвт байгууллагуудын мэдээллийн нэгдсэн санд мэдээллийг үнэн зөв бодитой тогтоосон хугацаанд тогтмол мэдээллүүлж, хяналт тавин ажиллаж байна.

Төрийн сангийн дансаар 89548,2 мян.төгрөгийн 105 ширхэг гүйлгээ хийгдсэн.

07-р сарын 23-ны өдрөөс 08-р сарын 24-ний өдрийн хооронд нийт 89548282 төгрөгийн 105 ширхэг гүйлгээг давхардсан тоогоор хийхдээ төлбөрийн хүсэлтийг үндэслэн цаг хугацаанд нь freeBalance программд шивсэн.

“Цагааннуур байгаль орчин” фэйсбүүк хуудсаар дамжуулан Байгаль орчны тухай хууль, Ойн тухай хууль бусад хууль тогтоомжийн сурталчилгааг тогтмол хүргэж байна.

Сэлэнгэ голын сав газрын захиргааны дарга, мэргэжилтнүүдтэй хамтран сумын төвийн уст цэг, цэвэрлэх байгууламжид хяналт шалгалтын ажил хийлээ.

“Шинэ бадрах” ХХК-ийн арчилгааны огтлолт, цэвэрлэгээний огтлолт, үйлдвэрлэлийн огтлолтын талбай тусгаарлалт, Гүн шүрэн, Баянбүрд нөхөрлөлүүдийн цэвэрлэгээний ажлын талбай тусгаарлалтуудад Ойн ангитай хамтран ажиллав.

Сумын төвийн нийтийн эзэмшлийн зам талбайг сар бүрийн 25-нд цэвэрлэж хэвшсэний дагуу төлөвлөгөөт цэвэрлэгээг зохион байгууллаа.

“Сум хөгжүүлэх сан”-гийн төслийн сонгон шалгаруулалтыг зарлаж, төсөлд хамрагдахаар санал ирүүлсэн 10 иргэнд сургалт зохион байгуулав.

Малчин, мал бүхий иргэдийн “Ноосны урамшуулал”-ын 193 материалыг хүлээн авч холбогдох материалыг мөн газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг ААН, иргэдийн ургац тогтоох ажлыг зохион байгуулж, иргэн ААН бүрээр гарган Сэлэнгэ аймгийн ХХАА-н газарт хүргүүлэв.

Шаамар сум:

Монгол Улсын Онцгой комисс, 2020 оны 02 тоот “Хичээл сургалтын үйл ажиллагааг эхлүүлэх зарим арга хэмжээг авах тухай журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллалаа.

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Засаг даргын 2020 оны 08 сарын 11-ний А/74 дугаартай “2020-2021 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай” удирдлага зохион байгуулах хангах, хүлээн авах, сумын хэмжээнд ургацыг урьдчилан тогтоолт явуулах, ургац хураалтыг чанартай зохион байгуулхад хяналт тавих, төр төсвийн байгууллага, айл өрхийн өвөлжилтийн бэлтгэл ажилд хяналт тавих, мал аж ахуйн урьдчилан сэргийлэх, хадлан тэжээл бэлтгүүлэх, хяналт тавих зэрэг ажлуудыг хийж зохион байгуулж тус бүр дээр ажлын хэсэг томилон ажлуулсан.

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын хууль эрх зүйн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд

аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсээс зохиох байгуулсан сумдад “Эрх зүйн хөтөч” бэлтгэх сургалт, цахим эрх зүйн хөтөч болох хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл, сурталчилгааны цахим сан “E-khutuch” портал цахим хуудсыг ашиглалтанд оруулах, танилцуулах, хэрэглээнд нэвтрүүлэх арга хэмжээг Сэлэнгэ аймагт зохион байгуулахад сумын төлөөллийг оролцуулж, холбогдох тоног төхөөрөмжөөр хангагдлаа.

“Шаамар сум ЗДТГ” фәсебүүк хаягаар дамжуулан шилжилт хөдөлгөөн, хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн гэрээний тухай, цар тахал ба хүний эрх, захиргааны байгууллагын шийдвэр ба иргэдийн оролцоо, хулгайн гэмт хэрэг, хуулиар олгосон иргэний эрх оролцоо, хөдөлмөрийн харилцаа, экологийн цагдаагийн алба зэрэг иргэдэд эрх зүйн мэдээллийг олгосон. Цахим эрх зүйн мэдээллийн хөтчөөр нийт 33 хүн үйлчлүүлсэн байна. Мөн оны 08 сарын 24-ний өдөр энэ ажлын үр дүнд хяналт шинжилгээ хийх үнэлгээний баг ирж ажиллаж, сумдын эрх зүйн хөтөч нар болон иргэдтэй уулзалт, ярилцлага зохион байгуулсан.

Хур системээр нийт 6 төрлийн лавлагаа иргэдэд олгосон.

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын татварын байгууллага нь 2020 оны Аж ахуй нэгжийн 2-р улирлын тайлан, 7-р сарын НӨАТ-ын тайланг цахимаар тус тус хүлээн авч ирцийг хянаж хүлээн авсан. Улс орон нутгийн төсөвт дараахь татварын төрлөөр орлогыг төвлөрүүлэн ажилласан.

- Улсын төвлөрсөн төсөвт ААНОАТ - 250000
- Аймгийн төвлөрсөн төсөвт ҮХЭХАТ – 617500
- Сумын төсвийн орлого ХХОАТ – 150000, ҮХЭХБОр – 65000 нийт 1082500 төгрөг төсөвт төвлөрүүлэн ажилласан.

Сэлэнгэ аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газарт Таримлын хөгжлийн үе, шат, ургацын төлөв байдлын тухай мэдээллийг суманд улаан буудай тариалсан 4 аж ахуй нэгжийн 2440 га талбайгаар гарган өгч ажилласан. Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2018 оны 08 дугаар сарын 24-ны өдрийн А-105 дугаар тушаалын 2 дугаар хавсралт Ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээг сумын Дэлгэрхаан, Охиндий багийн хүнсний ногоо тариалагч иргэдийн 2020 оны ургац хураалтаас Улаанбаатар, Дархан, эрдэнэт зэрэг хотуудад борлуулах төмс, хүнсний ногоонд мэдрэхүйн үзлэгийн дүн шилжилгээ хийж нийт 200 тн хүнсний ногоо 40 гаруй тээврийн хэрэгсэлд гэрчилгээ гарган өгч ажиллалаа.

Монгол Улсын Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэлийн тухай хууль 2020.09.01-ний өдрөөс хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан 8-р сарын 24-ний өдөр мэргэжлийн хяналтын газраас зохион байгуулсан цахим хуралд сумын сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч бүрэн хамруулсан.

Тарьмал ургамлын талбайд мал тэжээвэр амьтан орсон тухай дуудлага ногоочдоос 3 удааирсэн өргөдөл гомдлын дагуу тухай бүр газар дээр сумын хохирол тогтоох комисс ажиллаж 2 дуудлагын хохирлыг тогтоон хохирол учруулсан иргэнд иргэн, хохирсон иргэнд актыг хүлээлгэн өгч ажиллав.

Шаамар сумын 2020 оны намрын ургац хураалтын урьдчилсан балансыг үр тариа тариалсан Ундрагч, Билгүүндоодой, Мон-Апи, Гацуурт ХХК-ны талбай тус бүрээр гарган, Төмс хүнсний ногоо тариаланч иргэдийн талбайгаар явж ургацын урьдчилсан балансыг тогтоож ажиллалаа.

Орон нутгийн төсвийн орлогын бүрдэлт: 8-р сарын 25-ны байдлаар 57199,6 мян/төг орох төлөвлөгөөтэй ба 38036,9 мян/төг буюу 66 % -иар биелсэн байна. Аймгийн санхүүгийн дэмжлэг 8-р сарын 25-ны өдрийн байдлаар 701773,2 мян/төг авахаас 514316,2 мянган төгрөг буюу 73%-ийн санхүүгийн дэмжлэг авсан. Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилт нь 2020 оны 08 –р сарын 25-ны өдрийн байдлаар 100% авч ажиллаж байна.

Сум тосгоны төрийн сангаар өссөн дүнгээр нийт 16 байгууллагад 2 406 390 .2 мянган төгрөгийн дүнтэй 2235 ширхэг гүйлгээг хийж төрийн сангийн өдөр дутмын үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. 8-р сарын байдлаар орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн бүх байгууллага 2021 оны төсвийн төслийг дээд шатны байгууллагад хүлээлгэн өгч шилэн дансанд хуулийн хугацаанд байршуулж ажилласан.

Орхон голын ус нэмэгдсэнтэй холбогдуулан голын эрэг дагуу төмс хүнсний ногоо талиалагч иргэдтэй уулзан болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх анхааруулга санамж хүргүүлэн ажиллалаа. Мөн амралт зугаалгаар аялаж яваа аялагчдад үер усны сэрэмжлүүлэг мэдээг хүргэж, гарын авлага тарааж ажиллалаа.

Өвөлжилтийн бэлтгэл ажил хангахтай холбогдуулан сумын болон Сүхбаатар сумын иргэдэд хадлан тэжээл бэлтгэх ажлыг зохион байгуулж байна. Үүнд Сүхбаатар сумын 12, Шаамар сумын малчин, мал бүхий 78 иргэнд хадлангийн талбайг хувиарлан гэрээ хийж төлбөл зохих төлбөр хураамжийг Сэлэнгэ аймгийн газрын төлбөрийн санд байршуулан ажиллалаа.

2019 оны жилийн эцэст тоологдсон төллөх насны 10601 толгой хээлтэгч малаас 2020 оны 08-р сарын байдлаар 10601 толгой мал төллөж, төл бойжилт 100 хувьтай бойжиж байна. Зүй бус хорогдлоор 42 толгой мал бүртгэгдсэнээс 18толгой хээлтэгч мал хорогдсон байна.

Хэрэглээний үнийн нөөцийн судалгааг 10 аж ахуй нэгжээс 8-р сард 4 удаа авч сумын “Шуурхай штаб”-ыг мэдээллээр ханган ажиллаж байна. Судалгааны мэдээллийг 7 хоногт 2 удаа аж ахуйн нэгжүүдээс авч ажиллаж байгаа бөгөөд 8 сарын 20 ний өдрийн байдлаар Мах 990 кг, гурил 2,6 тн, будаа 5709 кг, төмс 480 кг, хүнсний ногоо 897 кг- н нөөцтэй байна. Нөөцийн мэдээ судалгааг аймгийн МХГ, ОБГ-т хүргүүлэн ажиллаж байна.

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН

ТАМГЫН ГАЗРЫНДАРГА

Ө.СУВДАА

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:

МЭРГЭЖИЛТЭН

Д.АЛТАНТУЯА